



# ХАМТЫН ТЭМДЭГ БОЛОН ТОХИРЛЫН ТЭМДГЭЭР ДАМЖУУЛАН БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮД БОЛОН КЛАСТЕРИЙН БИЗНЕСИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ

Улаанбаатар хот  
2023





In partnership with  
**Canada**



The Asia Foundation



ХАМТЫН  
ТЭМДЭГ БОЛОН  
ТОХИРЛЫН  
ТЭМДГЭЭР  
ДАМЖУУЛАН  
БИЗНЕС ЭРХЛЭГЧ  
ЭМЭГТЭЙЧҮҮД  
БОЛОН  
КЛАСТЕРИЙН  
БИЗНЕСИЙГ  
ХӨГЖҮҮЛЭХ  
БОЛОМЖ

Улаанбаатар хот

2023

## ГАРЧИГ

<b>ТАНИЛЦУУЛГА</b>	<b>8</b>
<b>1.1 Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд тулгардаг хүндрэл, бэрхшээлүүд. Хамтын болон тохирлын тэмдэгтэй болох хэрэгцээ, шаардлага</b>	<b>9</b>
<b>1.2 Барааны тэмдэг, тохирлын тэмдэг, хамтын тэмдгийн ялгаа, хэрэглээний хамрах хүрээ, онцлог</b>	<b>10</b>
1.2.1 Барааны тэмдэг	10
1.2.2 Тохирлын тэмдэг	11
1.2.3 Хамтын тэмдэг	13
<b>1.3 Кластерын хөгжил</b>	<b>14</b>
1.3.1 Бизнесийн кластеруудын төрөл	14
<b>1.4 Хамтын тэмдгийг кластерийн түвшинд, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн түвшинд хэрэглэх боломж</b>	<b>16</b>
1.4.1 Хамтын тэмдгийн хэрэглээ, үр нөлөө, давуу тал	16
1.4.2 Хамтын болон тохирлын тэмдгийг бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн кластерийн түвшинд, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн түвшинд хэрэглэх боломж	17
<b>1.5 Хамтын тэмдгийг кластерийн түвшинд болон бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн түвшинд хэрэгжүүлэх нь: үр дүн болон үр нөлөө</b>	<b>20</b>
1.5.1 Хамтын тэмдгийг хэрэгжүүлэх нь	20

<b>1.6</b>	<b>Олон улсын гэрээ, хэлэлцүүрүүдийн хүрээнд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн тохирлын тэмдэг ашиглах чадавхыг бэхжүүлэх</b>	<b>24</b>
1.6.1	Тохирлын тэмдгийг хэрэгжүүлэх арга зам	25
<b>1.7</b>	<b>Кластерийн болон эмэгтэй бизнес эрхлэгчдийн хүрээнд хамтын тэмдэг болон тохирлын тэмдгийг бий болгож хөгжүүлэхэд оролцогч талуудын оролцоо, эрх үүрэг, оролцооны загвар</b>	<b>27</b>
1.7.1	Хамтын тэмдгийг бий болгож хөгжүүлэхэд оролцогч талуудын эрх үүрэг, оролцооны загвар	27
1.7.2	Тохирлын тэмдгийг бий болгож хөгжүүлэхэд оролцогч талуудын эрх үүрэг, оролцооны загвар	29
<b>1.8</b>	<b>Хамтын тэмдгийн брэндинг: газарзүйн байршил, онцлог болон нийлүүлэлтийн сүлжээний өртөг зэргийг харгалзан үзэх нь</b>	<b>33</b>
<b>1.9</b>	<b>Дүгнэлт болон зөвлөмжүүд</b>	<b>36</b>
1.9.1	Дүгнэлт	36
1.9.2	Зөвлөмжүүд	37

**ХАМТЫН ТЭМДЭГ  
БОЛОН ТОХИРЛЫН  
ТЭМДГЭЭР  
ДАМЖУУЛАН  
БИЗНЕС ЭРХЛЭГЧ  
ЭМЭГТЭЙЧҮҮД  
БОЛОН  
КЛАСТЕРИЙН  
БИЗНЕСИЙГ  
ХӨГЖҮҮЛЭХ  
БОЛОМЖ**

## ТАЛАРХАЛ

Энэхүү судалгаа, замын зургийг Канадын Гадаад хэргийн яамны дэмжлэгтэй хэрэгжүүлж буй Азийн сангийн Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх (ЭЭЧБ) төсөл болон Монсерко ХХК хамтран 2022 оны 10 дугаар сараас 2023 оны 1 дүгээр сарын хооронд боловсруулав.

Хамтын тэмдэг болон тохирлын тэмдэгийг ашиглан бизнес эрхлэгч эмэгтэйчүүд болон эмэгтэй эзэдтэй кластеруудын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд чухал ач холбогдол бүхий энэхүү судалгаа, замын зургийг боловсруулахад үнэтэй хувь нэмрээ оруулсан бүх хүмүүс болон байгууллагуудад Азийн сангийн зүгээс чин сэтгэлийн талархал илэрхийлж байна.

Монсерко ХХК-ын судалгааны багийн ахлагч Б.Баясгалан болон багийн гишүүн Д.Бадарч, Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх төслийн баг Тришиа Төрболд, Гантуяагийн Цолмон, Алтанхундагын Цолмонтуяа, Түмэнцогтын Бөртгөлжин, Батзэвэгийн Оюу-Эрдэнэ болон Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэд ерөнхийлөгч Ц.Магнайбаатар болон түүний багт тусгайлан талархал илэрхийлж байна.

Азийн сангийн Монгол дах суурин төлөөлөгчийн газар энэхүү хараат бус судалгааг гүйцэтгэсэн бөгөөд судалгаанд багтсан аливаа агуулга нь Азийн сан болон түүний доноруудын үзэл бодлыг тусгаагүй болно.

## ТАНИЛЦУУЛГА

Энэхүү тайланд хамтын болон тохирлын тэмдгийн хэрэглээ, ач холбогдлын талаар мөн Монголын бизнес эрхлэгч эмэгтэйчүүд эдгээр тэмдгийг ашиглан өөрсдийн бизнесийг хөгжүүлэх боломжийн талаарх мэдээллийг нэгтгэн оруулсан. Монголд үйл ажиллагаа явуулдаг бичил болон жижиг бизнес эрхлэгчдийн олонх нь эмэгтэйчүүд байдаг ба бараа, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн сүлжээ сул хөгжсөн, тээвэрлэлт, түгээлт хийхэд асуудалтай, харилцаа, холбоо дутмаг, санхүүжилт авахад хүндрэлтэй гэх мэт төрөл бүрийн саад, бэрхшээлтэй тулгардаг. Ийм төрлийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн үйл ажиллагааг дэмжихэд шинэлэг арга хэлбэр, аргачлалыг ашиглах нь чухал юм.

Хамтын болон тохирлын тэмдэг ашигласнаар бизнесийн байгууллагууд өөрсдийн бизнесийн үр ашгийг нэмэгдүүлэх боломжтойгоос гадна зах зээл дээрх өрсөлдөх чадвараа сайжруулах боломжтой юм. Энэхүү тайланд дурьдсанаар хамтын болон тохирлын тэмдгийг ашиглаж бизнес эрхлэгч эмэгтэйчүүд зах зээл дээрх өөрсдийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний ялгарлыг бий болгож, улмаар урт хугацаандаа хэрэглэгчид, үйлчлүүлэгчдийн итгэлийг олж авах боломжтой.

Олон улсад худалдаа, арилжааг дэмжих, хөгжүүлэх чиглэлд олон төрлийн бодлого, стратегийг боловсруулан хэрэгжүүлдэг. Энэхүү судалгааны хүрээнд олон улсад хэрэгжсэн сайн туршлагуудыг судлах замаар тэдгээр туршлагыг Монгол улсад хэрэгжүүлэх оновчтой, зөв тогтолцоог бий болгох талаар дүн шинжилгээ хийсэн юм. Мөн цаашид хамтын болон тохирлын тэмдгийг ашиглан бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх боломж, гарцын талаар хөгжлийн байгууллагууд, бизнес эрхлэгч эмэгтэйчүүд, шийдвэр гаргагчид зэрэг төрөл бүрийн оролцогч талуудад чухал ач холбогдолтой замын зураглалыг боловсруулан энэхүү тайланд тусгасан.

Хамтын болон тохирлын тэмдгийг нэвтрүүлэх, ашиглах хамгийн оновчтой, үр ашигтай тогтолцоог бий болгох зорилгоор хэрэгжүүлсэн олон улсын туршлагыг судлах замаар Монгол улсад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй бизнес эрхлэгч эмэгтэйчүүд, кластеруудын хэрэгцээ, шаардлагад нийцэх онцлог тэмдгийг бий болгох арга замыг тодорхойлох нь энэхүү судалгааны үндсэн зорилгын нэг байсан юм. Мөн хамтын болон тохирлын тэмдгээр дамжуулан зорилтот бизнесийн бүлгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих, хамтарсан брэнд бүтээх, хөгжүүлэх, дэмжлэг, тусалцаа үзүүлэх боломжийг тодорхойлох зорилготой ажилласан.



## Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд тулгардаг хүндрэл, бэрхшээлүүд. Хамтын болон тохирлын тэмдэгтэй болох хэрэгцээ, шаардлага.

Хамтын болон тохирлын тэмдгийн ач холбогдол, үр нөлөө, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд бий болох боломжуудын талаар дурьдахаас өмнө эдгээр бизнес эрхлэгчид ямар нөхцөлд үйл ажиллагаа явуулдаг, ямар саад, бэрхшээлтэй тулгардаг талаар дурьдах нь чухал юм. Эмэгтэйчүүд давамгайлдаг бичил болон жижиг бизнес эрхлэгчид өдөр тутмынхаа үйл ажиллагаанд маш олон саад, бэрхшээлтэй тулгардаг. Эдгээр саад, бэрхшээл нь дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, инфляци, татварын орчин, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих тусгайлсан бодлого зэрэг маш олон гадаад болон дотоод хүчин зүйлстэй холбоотой байдаг. Микро түвшинд дараах төрлийн нэн яаралтай шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг дурьдаж болох юм:

1. **Хөрөнгө оруулалтын санхүүжилт:** Бизнесийн үйл ажиллагааг өргөтгөх хөрөнгө оруулалтын эх үүсвэр татах болон өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийг банк, санхүүгийн байгууллагаас зээл хэлбэрээр авахад хүндрэл учирдаг. Барьцаа хөрөнгө байхгүй эсвэл үнэлгээ хүрэхгүй гэдэг шалтгаанаас бичил болон жижиг бизнес эрхлэгчид банкнаас зээл авах бэрхшээлтэй байдаг. Банк бус санхүүгийн байгууллагаас зээл хүсэхэд хүүгийн хувь өндөр байдаг ба урт хугацааны хөрөнгө оруулалтын зээл авах боломжгүй тул эрсдэлтэй байдаг.
2. **Түүхий эдийн татан авалт:** Үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний тоо цөөн тул түүхий эд татах зардал өндөр байдаг ба бага хэмжээгээр татан авалт хийдэг.
3. **Борлуулалтын суваг:** Борлуулалтын суваг хязгаарлагдмал, ихэнх томоохон сүлжээ дэлгүүрүүд нийлүүлэх барааны доод хэмжээ болон төрөл зүйлийг заадаг.
4. **Маркетинг:** Бүтээгдэхүүн үйлчилгээгээ гадаадын зах зээлд гарган, хэрэглэгчдэд таниулахад тодорхой хугацаанд томоохон маркетингийн кампанит ажил хийх шаардлагатай болдог. Бизнес эрхлэгчдийн хувьд үүнийг өөрийн дотоод нөөц бололцоогоор хийхэд хүндрэлтэй байдаг ба мэдлэг, туршлага дутдаг. Мэргэжлийн байгууллагад хандахад өндөр зардал гардаг.
5. **Үйл ажиллагаа:** Хүний нөөцийн хувьд хязгаарлагдмал, шинээр ажилтан сургаж авахад цаг хугацаа их зарцуулдаг, чадварлаг ажилтан татах боломж муу байдаг. Мөн өртөг тооцох, үнэ тогтоох, өдөр тутмын үйл ажиллагааны менежмент, зардлын бүртгэл хийх зэрэгт мэргэшсэн ажилтан, хүний нөөц дутмаг байдаг.

Мөн судалгаанд хамрагдсан оролцогчдын дийлэнх нь бизнесийн дунд болон урт хугацааны төлөвлөлтгүй, өмнөх асуудлаа шийдвэрлээд дараагийн тулгамдсан асуудлаа шийдвэрлэх буюу "гал унтраах маягаар" бизнесээ явуулж байгаа нь ажиглагдсан. Эдгээр асуудлыг хамтын ажиллагааг сайжруулах, хамтарсан брэнд бий болгох, хөгжүүлэх, худалдан авалтын хамтын стратеги, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх замаар шийдвэрлэх боломжтой. Мөн бизнесийн байгууллагуудыг бүлэглэж, кластерийн зохион байгуулалтад оруулан, санхүүжилтийн механизмыг оновчтой болгох, мөн бизнес хөгжил, бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэлт, санхүү, нягтлан бодох бүртгэл, хүний нөөцийн менежментийн чиглэлээр сургалтын чадавхжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь оновчтой байх юм. Ийм төрлийн хамтарсан арга хэмжээ нь үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахаас гадна нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, маркетинг хийх, хүний нөөцийн гэх мэт зардлуудыг хэмнэх боломжийг бүрдүүлнэ.

## Барааны тэмдэг, тохирлын тэмдэг, хамтын тэмдгийн ялгаа, хэрэглээний хамрах хүрээ, онцлог

Барааны тэмдэг, тохирлын тэмдэг, хамтын тэмдэг зэрэг нь орчин үеийн худалдаа, арилжаа, бизнесийн үйл ажиллагаан дахь чухал ойлголтууд юм. Эдгээр нь нийлүүлэлтийн сүлжээний чухал бүрэлдэхүүн хэсгүүд ба үйлдвэрлэгчид, хэрэглэгчид болон үйлчилгээ үзүүлэгч нарын өдөр тутмын бизнесийн үйл ажиллагааг холбож өгч байдаг. Мөн эдгээр ойлголтууд дээр үндэслэн бизнес эрхлэгчид өөрсдийн бизнесийг хөгжүүлэх, зах зээлээ тэлэх, өөрийн гэсэн брэнд бараа, бүтээгдэхүүнийг бий болгож, таниулах стратеги, арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлж байна. Тиймээс барааны тэмдэг, тохирлын тэмдэг, хамтын тэмдгийн ялгаа, хэрэглээний цар хүрээ, зорилго, онцлогийг сайтар ойлгож үйл ажиллагаандаа нэвтрүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

### 1.2.1 Барааны тэмдэг

Барааны тэмдэг нь тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэж байгаа байгууллага, хувь хүнийг бусад үйлдвэрлэгчээс ялгаруулах, таниулах үндсэн зорилготой. Гэсэн хэдий ч тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хийц, стандартын хөндлөнгийн баталгаа болдоггүй.

Барааны тэмдэг нь тухайн бараа, үйлчилгээг тодорхойлох үг, үсэг, тэмдэг, дизайн эсвэл эдгээр зүйлсийн хослол байж болох ба тухайн бизнесийг зах зээл дээрх өрсөлдөгчдөөс нь ялгаруулж харуулдаг. Хамгийн эртний тэмдэг нь амьтдын тэмдэглэгээ байсан гэж үздэг бөгөөд тариачин, фермер эсвэл эзэн нь ямар амьтан хэний эзэмшлийнх болохыг ялгахад ашиглаж байв. Анх үүсэхдээ ямар нэгэн бараа, бүтээгдэхүүний эзэмшигчийг тодорхойлох зорилгоор ашиглагдаж байсан бол худалдаа арилжаа хөгжихийн хэрээр барааны тэмдэг нь илүү төрөлжиж хөгжжээ.

#### Жишээ:



Зураг 1

Энэхүү барааны тэмдэг эзэмшигч нь Мобиком корпораци бөгөөд барааны тэмдэг нь өрсөлдөгчөөс ялгарах, хэрэглэгчдэд танигдах зорилготой. Барааны тэмдэг нь дангаараа ямар нэг чанар, стандартын шаардлагын баталгаа болохгүй юм.



Зураг 2

Энэхүү барааны тэмдэг эзэмшигч нь Adidas AG групп бөгөөд барааны тэмдэг нь өрсөлдөгчөөс ялгарах, хэрэглэгчдэд танигдах зорилготой. Барааны тэмдэг нь дангаараа ямар нэг чанар, стандартын шаардлагын баталгаа болохгүй юм.

## 1.2.2 Тохирлын тэмдэг

Тохирлын тэмдэг нь аж үйлдвэржилтийн хурдацтай өсөлтийн улмаас 20-р зууны эхэн үед бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, стандартыг хянах, сайжруулах, хадгалах зорилготойгоор үүсэн бий болж, хөгжиж иржээ.

Тохирлын тэмдэг нь тодорхой стандартад нийцэж байгааг харуулсан нэр, тэмдэг, дүрслэл бөгөөд тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэгч нь тодорхой стандарт, шаардлагад нийцсэн гэдгийг илэрхийлдэг. Тохирлын тэмдэг нь дараах зүйлсийг илэрхийлнэ. Үүнд:

- Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар стандартыг хангасан байдал
- Бүтээгдэхүүн, үйлчилгээний гарал үүсэл
- Бүтээгдэхүүн, үйлчилгээг хийсэн материал, материалын орц, агууламж
- Бүтээгдэхүүн, үйлчилгээг хийсэн арга, технологи
- Бүтээгдэхүүн, үйлчилгээг хийсэн ажилтан/мэргэжилтний ур чадвар гэх мэт.

Тохирлын тэмдэг нь барааны тэмдгийн нэг төрөл боловч арай өөр төрлийн зорилгоор ашиглагддаг. Тохирлын тэмдэг нь тухайн бараа, бүтээгдэхүүн чанар стандартын шаардлага хангасан, хэрэглээнд нийцсэн гэсэн баталгааг хэрэглэгчдэд өгдөг бөгөөд ихэвчлэн гуравдагч талын баталгаа болдог. Барааны тэмдэг ба тохирлын тэмдгийн үндсэн ялгаа нь:

- **Хэрэглээ, ашиглалт:** Тохирлын тэмдгийг бүтээгдэхүүн үйлдвэрлэгч өөрөө ашигладаггүй бөгөөд үүний оронд эрх бүхий байгууллага (тохирлын үнэлгээний байгууллага, стандартын газар, мэргэжлийн холбоод, төрийн байгууллагууд гэх мэт) тэмдгийг ашигладаг.
- **Зориулалт:** Тохирлын тэмдэг нь бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийг заадаггүй, тухайн үйлдвэрлэгчийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг нөгөө үйлдвэрлэгчийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнээс ялгадаггүй. Өөрөөр хэлбэл, барааны тэмдэг нь тухайн үйлдвэрлэгчийн онцлогийг таниулдаг бол тохирлын тэмдэг нь тухайн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ нь чанар, стандартын шаардлага хангасан гэдгийг харуулна. Ингэснээр хэрэглэгч зах зээл дээрээс өөрийн хэрэглээ, шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнийг худалдан авах боломжтой болдог.
- **Зохицуулалт:** Тохирлын тэмдэг нь барааны тэмдгийг бодвол илүү нарийн зохицуулалттай байхыг шаарддаг. Тухайн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нь эсвэл тухайн бүтээгдэхүүн нь чанар, стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд дүгнэлт өгөх, хяналт тавих, олон нийтэд нээлттэй мэдээллэх зэрэг тогтолцоог бүрдүүлсэн байхыг шаарддагаараа онцлогтой.

Дүгнэн хэлэхэд, тохирлын тэмдэг нь барааны тэмдгийн онцгой нэг төрөл бөгөөд аливаа нэг бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ чанар, стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулдаг ба бүтээгдэхүүн үйлдвэрлэгч бий болгодоггүй харин эрх бүхий байгууллага олгодог тэмдэг юм.

Жишээ:



Зураг 3

## 1. USDA Organic

USDA Organic тохирлын тэмдэг нь АНУ-ын Хөдөө аж ахуйн яамнаас нэвтрүүлсэн тохирлын тэмдэг бөгөөд хүнсний болон бусад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг органик аргаар үйлдвэрлэсэн болохыг илэрхийлдэг. Органик аргаар бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах, улмаар экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, биологийн олон янз байдлыг хамгаалах зэргийг чухалчилдаг.

Нэг талаар, энэхүү тохирлын тэмдэг нь бүтээгдэхүүний чанарт хяналт тавих боломжийг олгож, тухайн салбарт бодлогын уялдаа холбоог хангахад ач холбогдолтойгоос гадна хэрэглэгчийн сонголтыг нэмэгдүүлдэг. Нөгөө талаар, энэ нь үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа ашиглаж буй арга технологийг таниулах, хүлээн зөвшөөрөгдсөн гуравдагч талын баталгаажуулалтаар дамжуулан тухайн бараа, бүтээгдэхүүний органик гэсэн статусыг баталгаажуулах ач холбогдолтой. Энэ нь хэрэглэгчийн тухайн бараа, бүтээгдэхүүний чанарт итгэх итгэлийг нэмэгдүүлэхээс гадна худалдаа, борлуулалтыг мөн нэмэгдүүлнэ.



## Mongolian Noble Fibre®



Зураг 4

## 2. Mongolian Noble Fibre

Монгол Улсад болон Дэлхийн оюуны өмчийн байгууллагад бүртгүүлсэн, ноос ноолууран бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилгоор бий болгосон тохирлын тэмдэг нь Mongolian Noble Fibre буюу Монголын Хаан Ширхэгт тохирлын тэмдэг бөгөөд энэхүү тэмдгийг Монгол ноолуурын үнэ цэнийг нэмэгдүүлэх, өндөр чанартай, нарийн ширхэгтэй ноолуурын стандартыг бий болгох, олон улсын жишигт хүргэх, баталгаажуулах замаар олон улсад премиум (дээд зэрэглэлийн) ноолуурыг брэнд болгох зорилгоор бий болгосон. Уг тэмдгийн эзэмшигчээр Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам, баталгаажуулалтын байгууллагаар Монголын Ноос Ноолуурын холбоо ажилладаг. Энэхүү тохирлын тэмдгийг нэхмэл, сүлжмэл бэлэн бүтээгдэхүүн болон хялгасыг ялгасан ноолуурт хөндлөнгийн баталгаажуулалт хийж олгодог байна.

### 1.2.3 Хамтын тэмдэг

Хамтын тэмдэг нь газар зүйн байршлаар холбогдсон үйлдвэрлэгчид, үйлчилгээ үзүүлэгчид эсвэл бизнесийн байгууллагууд нэгдэн, нийлж эзэмшдэг тэмдэг юм. Энэхүү тэмдгийг нэгдэн нийлсэн бүлэг эсвэл холбоод ашигладаг ба тухайн бүлэг, холбооны гишүүд ашиглах давуу эрхтэй. Ихэвчлэн аж ахуйн нэгжүүдийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний газарзүйн гарал үүсэл, чанар, материал, үйлдвэрлэлийн хэлбэр болон бусад нийтлэг шинж чанарыг ялгах тэмдэг гэж тодорхойлдог.

Хамтын тэмдэг тохирлын тэмдгээс хэрэглээ, зориулалтаараа ялгагддаг. Хамтын тэмдгийг бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тодорхой бүлэг, кластер эсвэл салбарын холбооны гишүүд ашиглаж болох бол тохирлын тэмдгийг тухайн тэмдэг эзэмшигчийн тодорхойлсон стандартад нийцсэн хэн ч ашиглаж болох юм.

Мөн хамтын тэмдэг нь хамтын маркетинг хийх, брэнд бий болгох, жижиг эсвэл бүс нутгийн онцлогтой бизнесийг олон улсад таниулах, хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой байсаар ирсэн.

#### Жишээ:



Зураг 5

### 3. Melinda алим

Италийн Трентино мужид байрлах The Val Di Non хөндийд тариалсан алиманд олгодог хамтын тэмдэг бөгөөд тус хөндийд үйл ажиллагаа явуулдаг 16 хоршооны 4,000 гаруй алим тариалагчид ашиглах боломжтой хамтын тэмдэг юм.

Тус бүс нутгийн тариаланчид 2000 гаруй жилийн турш Тренто мужийн The Val Di Non хөндийд алим тариалсан уламжлалтай. Далайн түвшнээс дээш 500-1000 метрийн хооронд байрлах газар зүйн онцлог болон уур амьсгал нь тус нутагт тариалсан алимыг өвөрмөц өнгөлөг, амтлаг, анхилуун үнэртэй болгодог байна.

1980-аад оны сүүлчээр тус хөндийн алим тариалагчид Италийн жимсний зах зээл дээр “Val di Non Apples” нэрээр борлуулагдаж буй алимны тоо хэмжээ тус хөндийд тариалсан алимны тооноос 3 дахин их байгааг олж мэдсэн бөгөөд тариаланчид жинхэнэ “Val di Non” алимыг хэрэглэгчдэд хялбар таних боломжийг олгохын тулд нийтлэг брэндийн нэрийн дор нэгдэхээр шийджээ. Жимс тариалагчид нь алим тариалах, хураах ижил төрлийн арга технологийг ашигладаг жижиг дунд үйлдвэрлэгчид байсан нь хамтын тэмдгийг бий болгоход дөхөм болсон байна.

Тус хөндийн алим тариалагчид хамтын тэмдгийг бүтээгдэхүүндээ нэвтрүүлж, бүгд дагаж мөрдөх дүрэм, арга ажиллагааг боловсруулсан бөгөөд сав баглаа боодлын нэгдсэн зохицуулалтыг хүртэл хийж, хамтран баталжээ. Үүний үр дүнд алимны тариалалтыг хамтын маркетингийн арга техниктэй хослуулан дотоодын болон экспортын зах зээлд бусдаас ялгарах онцлог, нэр хүнд, имиж бүхий чанартай бүтээгдэхүүнээр өрсөлдөх боломжтой болсон.

Өнөөгийн эдийн засгийн нөхцөлд бизнесийн байгууллагууд үйл ажиллагаагаараа нэгдэж, хамтран ажиллах нь түгээмэл болсон. НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллагын тодорхойлсноор<sup>1</sup> кластерууд нь “нийтлэг сорилт, боломжуудтай, үйл ажиллагааны хувьд харилцан уялдаатай аж ахуйн нэгжүүд, байгууллагуудын газарзүйн төвлөрөл” юм. Тэгэхээр кластерийг үйл ажиллагаагаараа холбогдсон үйлдвэрлэгчид, үйлчилгээ үзүүлэгчдийн тодорхой бүтэц, зохион байгуулалтад орсон нэгдэл гэж ерөнхийд нь тодорхойлж болно.

Монгол улсад кластер эдийн засгийг хөгжүүлэх чиглэлд олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн боловч хууль, эрх зүйн орчны болон санхүүгийн тогтолцооны зарим ойлгомжгүй эсвэл харилцан уялдаа, холбоогүй байдлаас шалтгаалан төдийлөн сайн хөгжөөгүй байна. Цаашид кластерийн тогтвортой хөгжлийг дэмжих, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд бодлого, эрх зүйн орчныг илүү нарийвчлан судлах, сайжруулах шаардлагатай. Мэдээж кластерийн хүрээнд өөр хоорондоо харилцаа холбоо бүхий аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах, чиглүүлэх хууль, тогтоомж, дүрэм журмыг боловсруулах нь чухал шаардлагатай юм.

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хувьд хамтран кластер зохион байгуулалтанд орж, улмаар хамтын тэмдэгтэй болсноор хамтын бүтээгдэхүүнийг хамтарсан маркетингийн хүрээнд хөгжүүлэх боломжтой юм. Ийм байдлаар хамтран ажиллаж чадвал өөрсдийн хамтран бүтээсэн бараа, бүтээгдэхүүний ялгарлыг зах зээл дээр бий болгож чадахаас гадна борлуулалтыг нэмэгдүүлж, улмаар нийлүүлэлтийн сүлжээний өртөг, зардлыг хуваалцах, бууруулах боломжтой. Үүнээс гадна олон улсын сайн туршлагууд дээр үндэслэн мөн өөрсдийн бий болгосон кластерийн онцлогт тохирсон хамтын тэмдэгтэй болсноор томоохон давуу талуудыг өөрсдөдөө бий болгож чадна. Юуны өмнө хэвтээ хэлбэрийн кластерийг бий болгож, кластерийн хамтын тэмдэгтэй болж, улмаар олон улсын зах зээл рүү гарах брэнд бүтээгдэхүүнийг бий болгон хөгжүүлэх нь хамгийн оновчтой стратеги байх юм.

### 1.3.1 Бизнесийн кластеруудын төрөл

#### Бүс нутгийн кластер

Бизнесийн байгууллагууд газар зүйн байршлаар хоорондоо ойрхон байрладаг давуу талдаа түшиглэн хамтран ажилладаг бөгөөд нэг салбарт харъяалагдах нь чухал биш юм. Жишээлбэл, нэг бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд нэгдэн нийлж бодлогоор томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийн бааз суурийг бий болгох боломжтой.

<sup>1</sup> UNIDO<sub>s</sub>\_CLUSTER\_APPROACH  
[https://www.unido.org/sites/default/files/2014-01/UNIDO<sub>s</sub>\\_CLUSTER\\_APPROACH\\_0.PDF](https://www.unido.org/sites/default/files/2014-01/UNIDO<sub>s</sub>_CLUSTER_APPROACH_0.PDF)

Жишээ нь, Цахиурын хөндийг дурьдаж болох бөгөөд татвар, санхүүгийн таатай орчин, дэд бүтцийг бий болгосноор үйл ажиллагааны уялдаа бүхий мэдээлэл технологийн томоохон кластерийг бий болгосон байна.

## **Салбарын кластер**

Салбарын кластер гэдэг нь нэг салбарт харъяалагддаг аж ахуйн нэгж, байгууллагуудын нэгдсэн сүлжээ гэж хэлж болох бөгөөд өөрсдийн зорилтот зах зээлд чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнд үйл ажиллагаагаа уялдуулан зохион байгуулж, нэгдэл бий болгож буй бизнесийн байгууллагууд юм. Жишээ нь: программ хангамжийн компаниуд эд анги үйлдвэрлэх, угсрах компаниудтай хамтран үйл ажиллагаагаа уялдуулж, Tesla компанид зориулан автомашин угсрах үйлдвэрийг барьж байгуулах боломжтой.

Салбарын кластер компаниуд өөрсдийн үйл ажиллагаа явуулж байгаа салбарын онцлогтой холбоотойгоор төрөл бүрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Кластерт оролцож буй байгууллагуудыг салбарын онцлог болон өртгийн сүлжээгээр нь хоёр ангилж болно. Үүнд:

- **Босоо кластер:** Бизнесийн байгууллагууд нь нийлүүлэлтийн сүлжээний өртгийг бууруулах зорилгоор нэгдэж болдог. Жишээ нь: Дахин боловсруулах замаар цаас үйлдвэрлэдэг байгууллага үйлдвэрлэсэн цаасаа хэвлэлийн газарт нийлүүлэх, эргээд хэвлэлийн газраас гарсан цаасны хог хаягдлаар дахин боловсруулсан цаас үйлдвэрлэх гэх мэт. Энэхүү үйл явцад цаас дахин боловсруулах үйлдвэрүүд үйл ажиллагаагаа уялдуулж хамтран ажилласнаар бүтээгдэхүүний өртөг буурах, ашиг нэмэгдэх гэх мэт эерэг үр дагавартай.
- **Хэвтээ кластер:** Ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, нэг төрлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд нэгдэж, нэгдсэн том брэнд бий болгох, нэг том захиалагчийн захиалга гүйцэтгэх гэх мэт. Жишээ нь дээр дурьдсан Melinda Val Di Non алимын брэнд.

## **Аж үйлдвэрийн кластер:**

Хамгийн нийтлэг бөгөөд хамгийн олон салбарыг хамарч чаддаг кластер юм. Голчлон уул уурхай, газрын тос, автомашины үйлдвэрлэл, нэхмэлийн үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, ложистик зэрэг салбарын компаниуд хамтран аж үйлдвэрийн кластераар үйл ажиллагаа явуулдаг. Ийм төрлийн кластерууд нь бизнесийн компаниуд, судалгааны болон санхүүгийн байгууллагууд, жижиг дунд үйлдвэрлэгчид болон тээвэр ложистикийн байгууллагууд зэрэг олон төрлийн байгууллагуудын уялдаа холбоог хангасан томоохон гинжин хэлхээ, харилцаа холбоог үүсгэдэг. Жишээ нь: автомашин үйлдвэрлэлийн салбар. Автомашины үйлдвэрлэлд шаардлагатай деталь, жижиг хэсгийг жижиг, дунд үйлдвэрлэгчид хангах бөгөөд автомашин үйлдвэрлэлийн томоохон компаниуд угсралт, техникийн хяналт шалгалт, борлуулалт зэрэг үйл ажиллагааг хариуцах бол санхүүгийн байгууллагууд оролцогч талуудын санхүүжилтийн схемийг тодорхойлж, санхүүжилтийн оновчтой механизмыг бүрдүүлэх гэх мэт чиглэлд ажиллана.

## Хамтын тэмдгийг кластерийн түвшинд, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн түвшинд хэрэглэх боломж

Өнөө үед зах зээлийн хатуу, ширүүн өрсөлдөөн дунд бүтээгдэхүүн, үйлчилгээгээрээ ялгарахын тулд үйлдвэрлэгч нар зайлшгүй брэндиг хийх шаардлагатай болдог. Хэрэглэгчид тухайн үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт эргэлзэх шаардлагагүй гэж итгэдэг бол, тухайн бараа бүтээгдэхүүнийг худалдан авснаараа нийгэмд эзлэх байр сууриа нэмэгдүүлдэг бол, мөн тухайн үйлдвэрлэгчийн үзэл бодол, философийг дэмжиж, санал нийлдэг бол тухайн брэндийг худалдан авч, заримдаа бүр илүү ч үнэ төлдөг байна. Гэвч жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд олонд танигдсан брэнд бий болгож, хөгжүүлэх шаардлагатай эх үүсвэр, хөрөнгө оруулалт дутагдалтай байдаг. Үүнийг шийдэх нэг гарц нь хамтын брэнд бүтээгдэхүүн бий болгох юм.

### 1.4.1 Хамтын тэмдгийн хэрэглээ, үр нөлөө, давуу тал

Oliver Gerguad болон Florine Livat нарын судалгаагаар<sup>2</sup> хамтын тэмдэг нь тухайн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын баталгаа болох бөгөөд тухайн бүлэг, нэгдлийн нийт гишүүдийн имиж, нэр хүндийг өсгөхөд эерэгээр нөлөөлдөг байна. Хэрэглэгчдийн хувьд хамтын тэмдгийн дор нэгдсэн аль нэг гишүүн байгууллагын бүтээгдэхүүнийг тусгайлан ялгаж үздэггүй. Хамтын тэмдэг бүхий брэндийг эзэмшигч байгууллага нь тухайн бараа, бүтээгдэхүүний онцлог, шинж чанар, байгууллагын цар хүрээ, нийт гишүүдийн тоо, зорилтот хэрэглэгчид, өрсөлдөөний орчин, дотоод болон гадаад зах зээл дээрх байр суурь зэргээрээ ялгагддаг. Хамтын тэмдгийг үүсгэх, бүртгүүлэх, ашиглах олон улсын эрхзүйн үндсийг Аж үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүний эрхийг хамгаалах Парисын конвенциор<sup>3</sup> бий болгосон. Уг конвенцийн дагуу гишүүн орнууд нь<sup>4</sup> тухайн улсын хуульд харш бус хамтын тэмдэг бүртгүүлэх, тухайн тэмдгийг эзэмшигчдийн эрхийг хамгаалах үүрэгтэй ажээ.

Дэлхийн ихэнхи улс орнуудад хамтын тэмдгийг холбогдох хууль эрх зүйн баримт бичгээр зохицуулж, хамгаалсан байдаг. АНУ, Их Британи, Итали, Австри, Испани, Турк, Швейцарь г.м улсууд Барааны тэмдгийн хуулиар зохицуулдаг бол Норвеги, Дани, Швед, Финлянд зэрэг улсууд хамтын тэмдгийн эрх зүйн зохицуулалтыг хийх тусгайлсан хууль гаргасан байна.

<sup>2</sup> Team versus individual reputations : a model of interaction and some empirical evidence (researchgate.net) [https://www.researchgate.net/publication/5179498\\_Team\\_versus\\_individual\\_reputations\\_a\\_model\\_of\\_interaction\\_and\\_some\\_empirical\\_evidence](https://www.researchgate.net/publication/5179498_Team_versus_individual_reputations_a_model_of_interaction_and_some_empirical_evidence)

<sup>3</sup> Paris Convention for the Protection of Industrial Property [https://www.unido.org/sites/default/files/2014-04/Paris\\_Convention\\_0.pdf](https://www.unido.org/sites/default/files/2014-04/Paris_Convention_0.pdf)

<sup>4</sup> Монгол улс тус конвенцид 1985 онд элсэн орсон



Хамтын тэмдэг нь ихэнх тохиолдолд тухайн тэмдгийг ашиглаж буй бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний газарзүйн гарал үүсэл, түүхий эд, үйлдвэрлэлийн арга болон бусад ялгарах онцлогийг илэрхийлдэг ба зах зээл дээрх бусад бараа, бүтээгдэхүүнүүдээс ялгарал бий болгох зорилготой ашиглагддаг. Хамтын тэмдгийг хувь хүн, хуулийн этгээдүүд хоорондоо нэгдэн байгуулсан холбоо өөрийн нэр дээр бүртгүүлж болдог. Олон улсад эдгээр холбоод нь компаниудын нэгдэл, сайн дурын холбоод, эсвэл төрийн байгууллагууд байж болдог туршлага байна. Хуульд өөрөөр заагаагүй бол хамтын тэмдгийг мөн холбогдох барааны тэмдгийг зөвхөн тус холбоонд харъяалагддаг байгууллагууд л ашиглах эрхтэй байна.

Хамтын тэмдгийг өмчлөгч буюу бүртгүүлсэн этгээд нь үйлдвэрлэн, борлуулж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын хяналтыг хариуцах үүрэгтэй. Бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах чанарын стандарт, шаардлагуудыг хамтын тэмдгийн дүрэм, журамд тодорхой зааж өгсөн байх ёстой бөгөөд энэхүү журам нь дэлхийн ихэнх орнуудад хамтын тэмдгийг бүртгүүлэх хүсэлтэд заавал хавсаргах ёстой баримт бичиг болдог. Мөн түүнчлэн энэхүү журамд аливаа зөрчлийн үед авах арга хэмжээний талаар тодорхой заасан байх шаардлагатай.

Хамтын тэмдгийг ихэнхдээ тухайн бүс нутагт хамааралтай, онцлог бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг таниулах, хөгжүүлэх зорилгоор ашигладаг ба бүтээгдэхүүний хамтарсан маркетинг хийж, түүхий эд худалдан авалт, борлуулалтыг нэг сувгаар явуулснаар орлого, ашгийг нэмэгдүүлэх давуу талтай. Тухайн бүс нутгийн иргэд, тэдгээрийн онцлог, соёл зэрэг нь хамтын тэмдэг бий болгох үндэс суурь юм. Хамтын тэмдэг нь тэмдгийг эзэмшигч гишүүд, тэдгээрийн нэгдсэн философийг илтгэх тэмдэг, үг зэрэг байж болно. Хэрвээ үр дүнтэй ашиглаж чадвал хамтын тэмдэг нь практик ач холбогдолтой хэрэгсэл ба зах зээл дээр бараа, бүтээгдэхүүний ялгарлыг бий болгох, бага зардлаар маркетинг хийх, бараа, бүтээгдэхүүний болон үйлдвэрлэлийн стандартыг сайжруулах зэрэг арга замуудаар гишүүн байгууллагуудын бизнесийг хөгжүүлэхэд ашиглагддаг арга хэрэгсэл юм.

#### **1.4.2 Хамтын болон тохирлын тэмдгийг бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн кластерийн түвшинд, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн түвшинд хэрэглэх боломж**

Кластер гэдэг нь нэг салбарт үйл ажиллагаа явуулдаг, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ нь зах зээлийн бүх сегментийн эрэлтийг хангаж байдаг компаниудын нэгдлийг хэлдэг. Зарим гишүүн компаниуд нь шууд өрсөлдөгч биш байх нь олонтаа. Хурдацтай хөгжиж буй Хятад, Энэтхэг зэрэг улс орнуудад жижиг, дунд бизнес эрхлэгчдийг кластер байдлаар хөгжихөд нь засгийн газрын зүгээс дэмжлэг үзүүлэн ажилладаг. Жишээ нь, маш хурдан хөгжиж буй технологи, хувцас загвар, эм үйлдвэрлэл, биотехнологи зэрэг салбаруудад кластер брэнд бий болгон хөгжүүлэхийг дэмжих нь түгээмэл байдаг.

Дэлхийн бусад улс орнуудын туршлагаас харахад үйлдвэрлэлийн зардлыг бууруулах нь зах зээлийн өрсөлдөөнд томоохон нөлөө үзүүлдэг. Ийм ч учраас борлуулалтын суваг нэмэх г.м зардал ихтэй үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулж, зардал хэмнэснээр жижиг, дунд бизнес эрхлэгчид кластераар ажиллахын үр шимийг хүртэх боломжтой. Кластераар нэгдэж, хамтран ажилласнаар урьд нь дангаараа даван туулахад хүндрэлтэй байсан олон асуудлыг хамтын хүчээр даван туулж, гадны зах зээл дээрх өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх боломжтой юм. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн кластер нь ихэвчлэн дараах үйл ажиллагааг явуулдаг. Үүнд:

- Түүхий эд болон бүрдэл хэсгүүдийг зохион байгуулалттайгаар, нэгдсэн байдлаар худалдан авах
- Хамтын тэмдгийн доор нэгдсэн маркетингийн үйл ажиллагаа зохион байгуулах
- Гадаад зах зээл дээр хамтарч ажиллах
- Үзэсгэлэн худалдаа, яармаг, экспо зэрэг үйл ажиллагаанд хамтран оролцох
- Борлуулалтын үйл ажиллагааг хамтран удирдах, зохион байгуулах (Жишээ нь, бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ, төрөлд хамгийн доод хэмжээний шалгуур тавьдаг томоохон сүлжээ борлуулагчдаар дамжуулан борлуулах, өөрсдийн бараа бүтээгдэхүүнийг бөөнөөр борлуулах сүлжээг бий болгох, тээвэр ложистик г.м)
- Үйлдвэрлэлийн хүчин чадлыг сайжруулах, санхүүгийн менежментийг оновчтой хийх, хууль эрхзүйн дэмжлэг авах г.м.

### **Бизнесийн зорилтот бүлэгт тохирсон тэмдгийг оновчтой сонгох тухай**

Хамтын болон тохирлын тэмдгийг бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн кластерийн түвшинд болон бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн түвшинд ашиглахын тулд тэмдэг тус бүрийн онцлог, хамрах хүрээ, бизнес загвартай уялдуулан сонгох шаардлагатай.

- ❖ *Хамтын тэмдэг гэж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн сайн дурын үндсэн дээр байгуулагдсан хуулийн этгээдийн нэгдсэн хяналтын доор түүний гишүүд ашиглах боломжтой, тухайн улс орны хуультай нийцүүлэн бий болгосон барааны тэмдгийг хэлнэ.*
- ❖ *Тохирлын тэмдэг гэж тухайн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь эсвэл үйлдвэрлэгч, үйлчилгээ үзүүлэгч нь тодорхой төрлийн стандартад нийцсэн гэдгийг эрх бүхий байгууллага гэрчлэн олгож буй нэр, тэмдэг, дүрс зэргээр илэрхийлэгдэж болох барааны тэмдэг юм.*

Хамтын тэмдэг болон тохирлын тэмдгийн ялгаа:

**Хүснэгт 1**

Хамтын тэмдэг (Collective mark)	Тохирлын тэмдэг (Certification mark)
<ul style="list-style-type: none"> <li>• Бүлэг, хамтрал, хоршоо, холбоодын гишүүд тухайн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний газарзүйн онцлог шинж чанар, үйлдвэрлэлийн арга технологийг таниулж, сурталчилах, маркетинг хийхэд ашиглана.</li> <li>• Стандарт, шалгуур үзүүлэлтэнд хүрэхэд дэмжлэг үзүүлнэ.</li> <li>• Тухайн бүлэг, хамтрал, хоршоо, холбоодын гишүүд ашиглах боломжтой.</li> <li>• Тухайн бүс нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо эзэмшинэ.</li> <li>• Лого, дүрс, зураг, эсвэл газар орны нэрийг оюуны өмчөөр бүртгүүлэх боломжтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Тухайн зорилтот зах зээл, бүтээгдэхүүн, үйлчилгээ, хэрэглэгчийн бүлэгт чиглэсэн байна</li> <li>• Ямар нэг стандарт, шалгуур үзүүлэлтийг тогтоож, баталгаажуулна. Олон нийтэд нээлтэй, өөрөөр хэлбэл тухайн стандарт, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа бол хэн ч ашиглаж болно.</li> <li>• Лого, дүрс, зургийг оюуны өмчөөр бүртгүүлэх боломжтой.</li> <li>• Хөндлөнгийн хараат бус байгууллага эзэмшиж, баталгаажуулж, хэрэглэх эрх олгоно.</li> </ul>

Дээрх шинж чанарууд дээр үндэслэн дүгнэхэд, хамтын тэмдгийг үйлдвэрлэл эрхлэгчдийн кластер ашиглах нь үр дүнтэй байх бол тохирлын тэмдэг нь бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд илүү ач холбогдолтой харагдаж байна.

Хамтын болон тохирлын тэмдгийг нэвтрүүлснээр дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудын өрсөлдөх чадварыг сайжруулж, Монгол улсын цаашдын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах боломжтой юм. Сүүлийн жилүүдэд аж ахуйн нэгж байгууллагууд өөрсдийн санаачилгаар нэгдэн, кластер байгуулах, улмаар хамтын болон тохирлын тэмдэг нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллах үйл явц ажиглагдаж байна. Үүний нэг жишээ нь хамтын болон тохирлын тэмдгийг нэвтрүүлэх, хөгжүүлэх оролдлогууд юм. Эдгээр санаачилгын үр дүнд жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг тогтворжуулах, зах зээлд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох, хадгалах, үйл ажиллагааны зардлыг бууруулж, борлуулалтыг нэмэгдүүлэх зэрэг эерэг нөлөө гарч байна. Үүнээс гадна хамтын ажиллагааны үр дүнд дунд болон урт хугацаанд салбарын бүтээмж, инновацыг дээшлүүлж, монополчлолын нөлөөг бууруулах боломжтой ба эдийн засаг дахь татварын орлогыг нэмэгдүүлж, стагфляцийн нөлөөг бууруулж, Монголын эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэх боломжтой.

## Хамтын тэмдгийг кластерийн түвшинд болон бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн түвшинд хэрэгжүүлэх нь: үр дүн болон үр нөлөө

Хамтын тэмдэг нь компаниудад кластерын зохион байгуулалтанд орж, хамтарсан брэндийг бий болгох, ажил үйлчилгээний нэгдсэн стандарт, чанарыг тогтоох замаар салбарын хөгжлийг удирдан чиглүүлэх боломжийг олгодог чухал арга хэрэгсэл юм. Хамтын тэмдгийг кластерийн түвшинд Монгол улсад хэрэгжүүлэхийн тулд кластерийн шинж чанарыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай. Үүнд: кластерийн зорилго, гишүүд, кластерийн үйл ажиллагааны хамрах хүрээ, бүтэц, зохион байгуулалт, дүрэм, журмууд, оюуны өмч болон чанар, стандартын талаарх асуудлууд зэрэг орно. Кластерийн түвшинд хамтын тэмдгийг бий болгох, хөгжүүлэхэд хамгийн түрүүнд шийдвэрлэх асуудал бол тэмдгийн оюуны өмчийн асуудал юм. Манай улсын хувьд кластер болон кластерийн байгууллагыг тодорхойлсон хууль эрх зүйн орчин байхгүй. Иймд хамтын тэмдгийг оюуны өмчийн байгууллагад тухайн салбарын холбоо эсвэл байгууллагын нэрээр бүртгүүлж болох хэдий ч цаашид гарах эрсдэлээс сэргийлэх нь зүйтэй.

Кластерийн үйл ажиллагааг сайтар зохицуулсан хууль, эрхзүйн орчин хараахан бүрэлдэж бий болоогүй, санхүүжилтийн тогтвортой системийг бий болгоход хүндрэлтэй мөн оюуны өмчийн найдвартай хамгаалалт байхгүй зэрэгтэй холбоотой ирээдүйд хүндрэл үүсч болзошгүй юм. Цаашид хамтын тэмдгийг нэвтрүүлж, кластерийн хөгжлийг хангахын тулд эдгээр эрсдэлийг даван туулах шаардлагатай.

### 1.5.1 Хамтын тэмдгийг хэрэгжүүлэх нь

Хамтын тэмдэг нь компаниудад кластерын зохион байгуулалтанд орж, хамтарсан брэндийг бий болгох, ажил үйлчилгээний нэгдсэн стандарт, чанарыг тогтоох замаар салбарын хөгжлийг удирдан чиглүүлэх боломжийг олгодог чухал арга хэрэгсэл юм. Энэхүү арга хэрэгслийг кластерийн түвшинд хэрэгжүүлэхийн өмнө дараах зүйлсийг нарийвчлан тодорхойлсон замын зургийг боловсруулсан байх шаардлагатай. Үүнд:

- Кластерийн зорилго: Хамгийн эхний алхам нь тухайн кластерийн ерөнхий зорилго, хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлох явдал юм.
- Кластерийн гишүүд, оролцогчид: Кластерийн алсын хараа, зорилго, зорилтуудыг хүлээн зөвшөөрсөн, үйл ажиллагаа нь тэдгээртэй нийцэж буй бизнесийн байгууллагуудыг гишүүнээр бүртгэж, нэгдмэл бүлэг, хамт олныг бий болгоно.
- Кластерийн хамрах хүрээ: Кластерийн үйл ажиллагааны цар хүрээ, зах хязгаарыг нарийвчлан тодорхойлно.
- Кластерийн бүтэц, зохион байгуулалт: Үйл ажиллагааг үр дүнтэй явуулахын тулд үүрэг, хариуцлагыг нарийвчлан тодорхойлсон, бүтэц, зохион байгуулалт сайтай байгууллагыг үүсгэн байгуулна.

- Кластерийн дүрэм, журам: Үйл ажиллагааг дэг журамтай, цэгцтэй явуулахын тулд тухайн кластерийн дотоод дүрэм, журмыг боловсруулан, даган мөрдүүлнэ.
- Оюуны өмч: Оюуны өмчийн бүртгэл, хамгаалалтыг бий болгох нь кластерийн хөгжилд чухал ач холбогдолтой юм.
- Стандарт, шаардлага: Хамтын тэмдгийг нэр хүндтэй авч явахын тулд нарийн стандарт, шаардлагыг боловсруулан, хэрэгжүүлнэ.
- Хамтын тэмдгийг бий болгох, хөгжүүлэх: Хамтын тэмдгийг олон нийтэд таниулах, үр нөлөөг нь нэмэгдүүлэх үүднээс хамтын тэмдгийг зорилготойгоор бий болгож, хөгжүүлнэ.
- Хамтын тэмдгийн хэрэглээ: Хамтын тэмдгийн хэрэглээтэй холбоотой дүрэм, журмыг мөрдөн ажиллаж, нэгдмэл байдлыг хангана.

Монгол улсын хувьд кластер үйл ажиллагааг сайтар зохицуулсан хууль, эрхзүйн орчин хараахан бүрэлдэн бий болоогүй байгаа нөхцөлд хамтын тэмдгийг оюуны өмчийн байгууллагад тухайн салбарын холбоо эсвэл байгууллагын нэрээр бүртгүүлж болох хэдий ч цаашид гарах эрсдэлээс сэргийлэх нь зүйтэй. Кластер байгуулж, хөгжүүлэхтэй холбоотой дараах эрсдэлүүд гарч болзошгүй юм:

- **Хууль, эрх зүйн орчин:** Кластерийн үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан хууль эрх зүйн зохицуулалтууд байхгүй байгаа нь томоохон хүндрэл, бэрхшээлийг бий болгож байгаа ба кластерийн санхүүжилтийн хөшүүрэг, механизмыг шийдвэрлээгүйгээс ихэнх санаачилгууд сайн дурын нэгдэл, хоршлоос цааш хөгжиж чадахгүй байна.
- **Санхүүжилтийн тогтолцоо:** Кластерын хөгжилд хамгийн чухал суурь болох санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлж чадаагүй байгаа бөгөөд бизнесийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор салангид байдлаар санхүүгийн эх үүсвэрийг хайн ажиллаж байна. Энэ нь урт хугацаандаа кластерийн сүлжээний тогтвортой байдалд эрсдэлтэй юм.
- **Оюуны өмч:** Гишүүд хамтын тэмдгийг оюуны өмчөөр хамгаалах нь маш чухал. Хамтын тэмдгийг хөгжүүлж, маркетинг, брэндинг хийж эхэлснээр тухайн тэмдгийг кластерийн бус гишүүд зөвшөөрөлгүйгээр бүтээгдэхүүндээ байршуулах, сурталчилах зэрэг эрсдэл үүсдэг тул хамгаалалтын арга хэмжээг зайлшгүй авах шаардлагатай.

Хамтын тэмдэг нь тухайн нэг салбарын хөгжлийг дэмжих арга хэрэгсэл байхаас гадна дээр дурьдсан саад, бэрхшээлийг даван туулж, Монголын бизнесийн кластеруудын хөгжлийг дэмжих хөшүүрэг нь болох боломжтой юм.

## Зураглал 1. Хамтын тэмдгийг бий болгох хөгжүүлэх зураглал

### 1-р үе шат. Кластер байгуулах, кластерийн зорилго зорилтыг тодорхойлох

Тухайн кластер ямар зорилго, зорилтын хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлж, кластерийн гишүүдийн нэгдмэл зорилго, зорилтыг тодорхойлох, бий болгох, хэрэгжүүлнэ.



### 2-р үе шат. Кластерийн оролцогч талуудыг тодорхойлох

Үйл ажиллагааны зорилт, зорилгын хүрээнд кластерийн оролцогч талуудыг тодорхойлох, тэдгээрийн эрхүүрэг, оролцооны хэм хэмжээг тодорхойлож, механизмыг бий болгох шаардлагатай. Оролцогч тал гэдэгт дараах талууд орж болно.

- Аж ахуйн нэгж
- Санхүүгийн байгууллага
- Судалгаа шинжилгээний байгууллага
- Засгийн газар болон төрийн байгууллага
- Сургалтын байгууллага
- Маркетингийн байгууллага

Эдгээр оролцогч талууд нийтлэг оролцогчид бөгөөд тухайн салбарын онцлогоос шалтгаалан янз бүр байж болно. Жишээ нь тухайн кластер сайн дурын үндсэн дээр нэгдэж бий болсон, кластерийн үйл ажиллагаанд төрийн байгууллагын үйл ажиллагааны оролцоо байхгүй тохиолдолд төрийн байгууллагыг үйл ажиллагаандаа оролцуулах шаардлагагүй юм. Иймд кластерийн зорилго, зорилтыг маш сайн тодорхойлох шаардлагатай.



### 3-р үе шат: Кластерийн бүтэц, зохион байгуулалтыг бий болгох

Кластерийн үйл ажиллагаа нь нэгдсэн нэг зорилгын төлөө үйл ажиллагаагаараа уялдсан боловч бие даасан субъектуудын үйл ажиллагаагны хоршил байдаг. Ийм нэгдлүүдийн үйл ажиллагааг тогтмол, жигд, ойлгомжтой байлгах үүднээс кластерийн бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалт, ажил үүргийн хүрээг маш тодорхой байлгах шаардлагатай. Ялангуяа хамтын тэмдгийг олгох, хяналт тавих, брэндинг хийх үйл ажиллагааг хариуцсан нэгжийг тодорхойлох, эрх үүргийг тодорхой байлгах нь оновчтой.



### 4-р үе шат. Кластерийн дүрэм, журмыг бий болгох

Кластерийн дотоод үйл ажиллагааг уялдуулах, үүний зэрэгцээ хамтын тэмдгийг кластерийн түвшинд бий болгож хөгжүүлэхэд хамгийн чухал бодлогын бичиг баримт бол кластерийн дүрэм, журам юм. Кластерийн дотоод үйл ажиллагаандаа мөрдөх дүрэм, журмыг тогтоохоос гадна кластерийн гишүүд хамтын тэмдгийг бүтээгдэхүүн үйлчилгээндээ хэрхэн хэрэглэх, тэмдгийг хэрэглэх дүрэм, журмыг тогтоосноор хамтын тэмдгийн үнэ цэнийг хадгалах, нэгдсэн маркетинг брэндингийн бодлого хэрэгжүүлэх боломжтой болох юм.



### 5-р үе шат. Стандарт буюу шаардлага, шалгуур

Хамтын тэмдэг бий болгох, хамтын тэмдгийн шалгуур үзүүлэлтийг тогтоох нь кластерийн үйл ажиллагааны онцлог, стратегитай салшгүй холбоотой. Кластер нь үйл ажиллагааны чиглэл, бодлого, гишүүнчлэл зэрэг өөрийн онцлог байдлаас шалтгаалан хамтын тэмдэг бий болгох шаардлагатай эсэх, хамтын тэмдгээр дамжуулан брэнд бий болгох эсэх нь шалтгаална. Жишээ нь: Зөгийн бал үйлдвэрлэгчид нэгдэн нийлж кластерийн тогтолцоог бий болгож гадаад зах зээлд "Монголын органик зөгийн бал" нэрээр хамтын тэмдэг бий болгох, нэгдсэн брэнд бий болгох боломжтой бөгөөд ингэхийн тулд органик зөгийн бал гэдэг тодорхойлолт, техникийн үзүүлэлтийг кластерийн гишүүд өөрсдөө тодорхойлж, тогтсон шаардлага шалгуур хангасан тохиолдолд хамтын тэмдэг хэрэглэх эрхийг олгодог байхаар шаардлага шалгуураа тогтоож болно.



### **6-р үе шат. Хамтын тэмдгийг бий болгох, хөгжүүлэх**

Хамтын тэмдэг бий болгохын тулд кластерийн гишүүд кластерийн стратеги, үзэл санааг шингээсэн нэгдсэн брэндинг, шаардлага, шалгуурыг нэгдсэн байдлаар тодорхойлох шаардлагатай. Үүнд:

- Хамтын тэмдгийн зорилго, онцлог
- Шалгуур үзүүлэлт (Стандарт)
- Хамрах хүрээ
- Брэндинг



### **7-р үе шат. Хамтын тэмдгийг оюуны өмчөөр бүртгүүлэх**

Тухайн хамтын тэмдгийн оюуны өмчийн газар бүртгүүлж эрхийн хамгаалалт авсан байх шаардлагатай. Ингэхийн тулд эхний ээлжинд тэмдэг эзэмшигч, тэмдгийн илэрхийлэл (дүрс, хэлбэр), тэмдгийн тодорхойлолт (агуулга, дүрслэл), тэмдгийн төрөл (барааны, тохирлын, хамтын, газар зүйн) зэргийг тодорхойлж, тэмдэг хэрэглэх дүрэм, журмыг бий болгосон байх шаардлагатай. Монгол Улсын хувьд ЗГ-ийн хэрэгжүүлэгч агентлаг “Оюуны өмчийн газар” бүртгэл хийж, эрхийн хамгаалалтанд авах бөгөөд хэрвээ цаашид олон улсын түвшинд хамгаалалтанд авах, бүртгүүлэх шаардлагатай бол Дэлхийн оюуны өмчийн байгууллага (World Intellectual Property Organization)-д хандах боломжтой.



### **8-р үе шат. Хамтын тэмдгийн хэрэглээ**

Хамтын тэмдэг нь ганц компанийн өмч бус тодорхой хэсэг бүлэг бизнес эрхлэгчдийн хамтын өмч, бизнесийн цар хүрээ, брэндингтэй салшгүй холбоотой болж хөгжих учраас хамтын тэмдэг хэрэглэгчдээс бизнесийн тогтвортой байдал чухал бөгөөд талуудын нийтлэг эрх ашгийг хангасан дүрэм, журам, үйл явц, хэрэглээг бий болгох шаардлагатай. Мөн кластер оролцогчдын бизнесийн онцлогоос шалтгаалан хэрэглэгчид хүрэх бүтээгдэхүүн сав баглаа боодол, бизнес эрхлэгчийн стратеги зэргээс шалтгаалан хамтын тэмдэг хэрэглэх үйл явцыг оновчтой, хүртээмжтэй, кластер болон кластерийн гишүүдийн аль алиных нь эрх ашгийг хангасан байдлаар хэрэглээг зохицуулах шаардлагатай. Жишээ нь: А компанийн үйлдвэрлэдэг “зөгийн бал бүтээгдэхүүн дээр компанийн брэндингтэй уялдсан хаяг, сав баглаа боодол, компанийн лого болон кластерийн хамтын тэмдгийг хэрхэн оновчтой уялдуулах дүрэм, журам, брэндингийн бодлоготой байх нь чухал ном.



### **9-р үе шат. Хамтын тэмдгийн хяналт**

Кластерийн гишүүдийн хүрээнд хэрэглэгдэж буй хамтын тэмдэг нь брэндингийн бодлогын хүрээнд хэрэглэгдэж байгаа эсэх, хэрэглэх зөвшөөрөл авсан субъект хэрэглэж буй эсэх, оюуны өмчийн зөрчил гарч буй эсэхийг хянах шаардлагатай.

## Олон улсын гэрээ, хэлэлцүүрүүдийн хүрээнд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн тохирлын тэмдэг ашиглах чадавхыг бэхжүүлэх

Олон улсын гэрээ гэдэг нь тусгай журмын дагуу, Олон Улсын Стандартын Байгууллагын (ISO) бүтцээс гадуур семинар, хэлэлцүүлгүүдийн үр дүнд бэлтгэж, боловсруулан, оролцохыг хүссэн бүх талуудын зөвшилцлөөр баталдаг эрх зүйн баримт бичиг юм. Олон улсын гэрээг нийтлэгдсэнээс хойш гурван жил тутамд хянан үздэг ба олон нийтэд нээлттэй байлгадаг. Товчоор хэлбэл, энэ нь олон улсын стандартын өмнөх үе шат бөгөөд эхний ээлжинд оролцогч талууд Олон Улсын Стандартын Байгууллагын (ISO) тусгай хорооны хурлаар хэлэлцүүлэлгүй, дотоод журмын дагуу батлах боломжтой оролцогч талуудын тохиролцсон хэм хэмжээ гэж ойлгож болно.

Шведийн Стандартын Хүрээлэн (Swedish Institute for Standards) болон Олон Улсын Худалдааны Төв (ITC) хамтран “Бизнес эрхлэгч эмэгтэй” (Women-owned business)-г хэрхэн тодорхойлох талаар Олон улсын стандартын байгууллагын (ISO) International Workshop Agreement ISO IWA 34:2021 баримт бичгийг боловсруулж, 2021 онд баталжээ<sup>5</sup>. Энэхүү баримт бичиг нь эмэгтэй бизнес эрхлэгчдийн төрийн болон хувийн хэвшлийн худалдан авалтад оролцох саад бэрхшээлийг бууруулах, эмэгтэйчүүдийн чадавхыг бэхжүүлэх, урамшууллын болон гэрчилгээжүүлэх хөтөлбөрүүдэд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх зорилготой юм.

Энэхүү гэрээнд эмэгтэй эзэмшилтэй бизнес, эмэгтэй удирдлагатай бизнес, эмэгтэй удирдлагатай бизнесийн хоршоо, албан бус бизнес эрхлэгч гэх мэт эмэгтэй бизнес эрхлэгчтэй холбоотой тодорхойлолтуудыг нарийвчлан боловсруулж тусгажээ. Эдгээр нэгдсэн тодорхойлолтуудыг эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх, тэр дундаа худалдан авалт, худалдаа дэмжих төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд ашиглах боломжтой ба олон улсад эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийн талаар харьцуулж болохуйц дата, мэдээлэл цуглуулахад мөн ашиглах юм.

Тус баримт бичигт тодорхойлсноор:

- **Эмэгтэй эзэмшилтэй бизнес (Women owned business):**

Нэг буюу хэд хэдэн эмэгтэй бизнесийн 50-иас дээш хувийг эзэмшдэг, удирдлага (3.5), хяналт (3.7) нь нэг буюу хэд хэдэн эмэгтэйд харъяалагддаг, тухайн бизнесийн эрх зүйн баримт бичиг, санхүүгийн дансанд эмэгтэй хүн гарын үсэг зурдаг, бусад аж ахуйн нэгжээс (эмэгтэй удирдлагатай бус) хараат бусаар үйл ажиллагаа явуулдаг бизнесийг (3.10) хэлнэ.

<sup>5</sup> ISO - IWA 34:2021 - Women's entrepreneurship - Key definitions and general criteria  
<https://www.iso.org/standard/79585.html>



- **Эмэгтэй удирдлагатай бизнес (Women-led business):**

Бизнесийн 25-аас доошгүй хувийг нэг буюу хэд хэдэн эмэгтэй эзэмшдэг, удирдлага (3.5), хяналт (3.7) нь нэг буюу хэд хэдэн эмэгтэйд харъяалагддаг, ТУЗ-ийн гуравны нэгээс доошгүй нь эмэгтэйчүүдээс бүрддэг (хэрвээ тухайн байгууллагад ТУЗ байдаг бол), эмэгтэй хүн бизнесийн эрх зүйн баримт бичиг, санхүүгийн дансанд гарын үсэг зурдаг, бусад аж ахуйн нэгжээс (эмэгтэй удирдлагатай бус) хараат бусаар үйл ажиллагаа явуулдаг бизнесийг (3.10) хэлнэ.

- **Эмэгтэй удирдлагатай бизнесийн хоршоо (Women-led cooperative):**

Нийт саналын 50-иас дээш хувийг эмэгтэйчүүд эзэмшдэг, хэрвээ үйл ажиллагааны бүтцэд ТУЗ байгаа бол удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь эмэгтэйчүүд, үйл ажиллагааны бүтцэд удирдлагын баг байгаа бол удирдах албан тушаалын дийлэнх хувийг эмэгтэйчүүд эзэлдэг хоршоог хэлнэ.

Дээр дурьдсан шаардлагуудад нийцсэн тохирлын тэмдэг бий болгож, хөгжүүлэх нь хэрэгжүүлэх шаардлагатай чухал арга хэмжээ юм. Тохирлын тэмдэг нь зах зээл дээр тухайн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний ялгарлыг бий болгох чухал арга хэрэгсэл ба бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд ашигласан түүхий эд, материал, үйлдвэрлэлийн процесс, чанар болон бусад чухал онцлог шинж чанаруудаараа стандарт, шаардлагад нийцэж байгааг баталгаажуулж байгаа юм<sup>6</sup>.

### **1.6.1 Тохирлын тэмдгийг хэрэгжүүлэх арга зам**

Тохирлын тэмдгийг бий болгож хөгжүүлэх нь тухайн тэмдгийг бий болгож, хөгжүүлж буй субъектийн зохион байгуулалт, маркетинг, стандарт хөгжүүлэлтийн ур чадварын асуудал бөгөөд гадны оролцоо бага байдаг. Өөрөөр хэлбэл, хамтын тэмдгийн хувьд оролцогч талууд тэмдгийн хэрэглэх хүрээ, брэндинг, стандартыг тодорхойлж, санал нэгдэх шаардлагатай байдаг бол тохирлын тэмдгийн хувьд зөвхөн тэмдэг хөгжүүлэх субъект дангаараа хэрэглэх хүрээ, стандартыг тогтоож болдог.

Эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан тохирлын тэмдгийг бий болгоход дараах 4 үе шат шаардлагатай.

---

<sup>6</sup> Law on Trademarks and Geographical Indications 3.1.3

## Зураглал 2. Тохирлын тэмдгийг бий болгох, хөгжүүлэх зураглал



## 1.7

### Кластерийн болон эмэгтэй бизнес эрхлэгчдийн хүрээнд хамтын тэмдэг болон тохирлын тэмдгийг бий болгож хөгжүүлэхэд оролцогч талуудын оролцоо, эрх үүрэг, оролцооны загвар


Хамтын болон тохирлын тэмдэг анх нэвтрүүлэх үед оролцогч талуудын эрх, үүрэг, идэвхтэй оролцоог хангах нь чухал байдаг.

Доор оруулсан загвар нь хамтын болон тохирлын тэмдэгт аль алинд нь тохиромжтой ба кластераар ажиллаж байгаа байгууллагууд, хоршоод, холбоод болон бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хамтын брэндингийн ач холбогдол, үнэ цэнийг ойлгоход чухал юм. Энэхүү загвар нь тухайн тэмдгийн чанар, үр ашиг, нэгдмэл байдлыг зах зээл дээр илтгэж байдаг. Ийм загварыг тухайн байгууллагын онцлог шинж чанар, тэр дундаа үйл ажиллагааны цар хүрээ, гишүүдийн тоо, бүтэц, үүрэг, хариуцлага зэрэг дээр үндэслэн засаж сайжруулах боломжтой.

#### 1.7.1 Хамтын тэмдгийг бий болгож хөгжүүлэхэд оролцогч талуудын эрх үүрэг, оролцооны загвар

Доорх зурагт хамтын тэмдгийг олгох, хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтын оновчтой загварыг харуулсан байна.


Зураглал 3. Хамтын тэмдгийг олгох бүтэц, зохион байгуулалт



## • Гишүүдийн хурал

Гишүүдийн хурал нь кластер байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл, гишүүдийн эрх, үүрэг зэргийг тодорхойлж, батлах, Удирдах хороог томилох эрх, үүрэгтэй ажиллана.

### Зураглал 4. Хамтын тэмдэг олгох үйл явц



## • Кластерийн удирдах хороо

Тус хороо нь хамтын тэмдэгний бүрдэл хэсгүүдийг тодорхойлох эрхтэй ба хороонд кластерийн гишүүд болон шийдвэр биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх гадны аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийг оруулж болно.

## • Гүйцэтгэх захирал

Хамтын тэмдэг бий болгох, хөгжүүлэхтэй холбоотой шийдвэр гаргана.

## • Кластерийн гишүүд

Гишүүд нь хамтын тэмдэг бий болгох, хөгжүүлэх, тэмдгийн стандарт, шаардлага, шалгуур үзүүлэлтүүд, дүрэм журам зэргийг бий болгож, боловсруулахад үүрэг оролцоотой байна. Мөн кластер доторх дүрэм, журмыг даган мөрдөж, өөрсдийн бүтээгдэхүүнд тэмдэг хэрэглэх, стандарт, шаардлагыг хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх үүрэг хүлээнэ.

## • Хамтын тэмдэг олгох байгууллага

Тус байгууллага нь тэмдгийн шаардлага, шалгуурыг бий болгох, үүнтэй холбоотой дүрэм, журам, үйл явцыг боловсруулах үүрэгтэй. Ийм төрлийн байгууллага нь кластерийн гишүүд, бусад оролцогч талуудаас хараат бус үйл ажиллагаа явуулах нь тохиромжтой байдаг. Хамтын тэмдэг авах нь зарим тохиолдолд амар хялбар боловч кластерийн брэнд бүтээгдэхүүн нь олон улсад нэр хүндтэй, стандартын шаардлага өндөр тохиолдолд тэмдэг олгох үйл явц нь нарийн төвөгтэй болох ба мэргэжлийн ур чадвар бүхий хөндлөнгийн баг ажиллах шаардлага үүсдэг.

### Хүснэгт 2. Хамтын тэмдэг олгох оролцогч талуудын эрх, үүрэг

Оролцогч тал	Эрх, үүрэг
Кластерийн удирдах хороо	<ul style="list-style-type: none"> <li>Хамтын тэмдэг олгох бүтэц, зохион байгуулалтыг бий болгох, батлах</li> <li>Кластерийн бодлоготой уялдуулж хамтын тэмдгийн зорилго, стратегийг батлах</li> </ul>
Гүйцэтгэх захирал	<ul style="list-style-type: none"> <li>Хамтын тэмдгийг хөгжүүлэх, баталгаажуулах үйл явцыг бий болгох, батлах</li> <li>Хамтын тэмдэг олгох үйл явцыг зохион байгуулах</li> <li>Хамтын тэмдэг олгох, цуцлах шийдвэр гаргах</li> </ul>

Баталгаа-жуулалтын алба	<ul style="list-style-type: none"> <li>• Хамтын тэмдгийн шалгуур, шаардлагад нийцэж байгаа эсэхийг тогтоох</li> <li>• Баталгаажуулалтын дүрэм, журмыг бий болгох, үйл ажиллагаандаа мөрдөх</li> <li>• Сургалт зохион байгуулах</li> </ul>
Кластерийн гишүүд	<ul style="list-style-type: none"> <li>• Кластерын болон хамтын тэмдэг хэрэглэх дүрэм, журмыг дагаж мөрдөх</li> <li>• Үйл ажиллагааны дүрэм, журам, бүтээгдэхүүний чанар стандартыг мөрдөх, хангах</li> <li>• Хамтын тэмдгийн нэр хүндийг унагахгүй байх</li> </ul>
Орон тооны бус хороод (Заавал бус)	<ul style="list-style-type: none"> <li>• Ёс зүйн хороо, санал гомдол шийдвэрлэх хороо зэрэг орон тооны бус бүтцийн нэгжийг кластер байгууллагын онцлог, зохион байгуулалтаас шалтгаалж сонголтоор бий болгох боломжтой бөгөөд тэдгээр нь өөрсдийн дүрэм, журмын дагуу үйл ажиллагаа явуулна.</li> </ul>

## 1.7.2 Тохирлын тэмдгийг бий болгож хөгжүүлэхэд оролцогч талуудын эрх үүрэг, оролцооны загвар

Бизнесийн байгууллагууд тохирлын тэмдгийг ихэвчлэн өөрсдийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ цэнийг нэмэгдүүлэх, тодорхой стандарт, шаардлагад нийцэж буйг баталгаажуулах, улмаар хэрэглэгчдэд чанарын баталгаа, сэтгэл ханамжийг өгөх зорилгоор ашигладаг.

### Хэрэгжүүлэх үе шатууд

1

#### Хэрэгцээ шаардлагыг тодорхойлох

**Хийх зүйл:** Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудлууд, хүндрэл бэрхшээлийг тодорхойлох, тэдгээрийг шийдвэрлэх арга механизм, уялдаа холбоог тодорхойлно.

**Оролцогч талууд:** Зах зээлийн судалгааны байгууллага, Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих, чадавхжуулах дотоодын болон олон улсын төсөл хөтөлбөрүүд

2

#### Тохирлын тэмдгийг бий болгох

**Хийх зүйл:** Хэрэгцээ шаардлагад үндэслэн тохирлын тэмдгийн хүрээ, тодорхойлолтууд дүрэм журмыг бий болгох, тэмдгийн ашиг тус, үр нөлөөг тодорхойлно.

**Оролцогч талууд:** Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих, чадавхжуулах дотоодын болон олон улсын төсөл хөтөлбөрүүд, тохирлын үнэлгээний байгууллага

3

#### Оролцогч талуудын бий болгох

**Хийх зүйл:** Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн бизнесийг тохирлын тэмдгээр дамжуулан дэмжих эрмэлзэлтэй оролцогч талуудыг тодорхойлж хэрхэн, яаж дэмжих гэдгийг тодорхойлно.

**Оролцогч талууд:** Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих, чадавхжуулах дотоодын болон олон улсын төсөл хөтөлбөрүүд, банк санхүүгийн байгууллагууд

4

#### Тохирлын тэмдгийг олгох

**Хийх зүйл:** Тохирлын тэмдгээр дамжуулан бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн бизнесийг дэмжих, дэмжлэг үзүүлэх оролцогч талуудыг тодорхойлсон бизнес загварыг бий болгосноор тохирлын тэмдгийг олгож эхэлнэ.

## Оролцогч талуудын зураглал

Тохирлын тэмдгийг бий болгох, бизнес эрхлэгчид бүтээгдэхүүндээ хэрэглэх нь сайн дурын үндсэн дээр хийгддэг ба тухайн бизнесийн зорилго, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээнээс хамаардаг. Эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан тохирлын тэмдгийг бий болгох, хэрэгжилтийг хангахад оролцогч талуудыг дараах байдлаар тодорхойлов.


### Хүснэгт 3. Тохирлын тэмдгийн оролцогч талуудын зураглал

	Үйл ажиллагаа	Оролцогч тал	Хийгдэх үйл ажиллагаа
Тодорхойлох	Эрэлт, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох	Зах зээлийн судалгааны байгууллага (Зах зээлийн төлөв, хэрэглэгчийн судалгаа, эрэлт хэрэгцээг судлах зэрэг үүрэгтэй оролцоно. Жишээ нь: ММСГ, IRIM, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв гэх мэт)	❖ Тулгамдаж буй асуудлыг тодорхойлох
		Тохирлын үнэлгээний байгууллага. (Зах зээлийн судалгаанд үндэслэн хэрэглэгч, худалдан авагчдад тохирсон баталгаажуулалтын схемийг боловсруулж бий болгох үүрэгтэй оролцоно. Жишээ нь: Стандарт хэмжил зүйн газар, Монсерко ХХК гэх мэт)	❖ Стандарт, дүрэм журам боловсруулах, талуудаас санал авах ❖ Тохирлын үнэлгээний тогтолцоог бий болгох ❖ Тэмдэг хэрэглэх эрх олгох, цуцлах
Хэрэгжүүлэх	Тэмдгийг бий болгох, дүрэм журам боловсруулах, тэмдгийг олгох	Мэргэжлийн холбоод (Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажилладаг мэргэжлийн холбоо, ТББ-ууд байж болно)	❖ Стандарт, дүрэм журам боловсруулахад оролцох, саналаа өгөх ❖ Бизнесийн үйл ажиллагаатай уялдан зөвлөмж, зөвлөгөө боловруулах ❖ Дэмжлэг үзүүлэх байгууллагатай холбох
		Төсөл хөтөлбөрүүд (Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах, дэмжих, эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажилладаг олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүд тохирлын тэмдэг хэрэглэгч байгууллагад бизнесийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэх мэт)	❖ Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах ❖ Стандарт, дүрэм журам боловсруулахад саналаа өгөх ❖ Дэмжлэг үзүүлэх байгууллагатай холбох
		Бусад	❖ Дэмжлэг үзүүлэх байгууллагатай холбох
	Тэмдэг хэрэглэх	Эмэгтэй бизнес эрхлэгчид (Тохирлын тэмдэг хэрэглэгч бизнес эрхлэгч эмэгтэйчүүд бүтээгдэхүүнээ ялгаруулах, таниулах, сурталчилах зорилгоор тэмдэг хэрэглэнэ)	❖ Тэмдгийг заагдсан дүрэм, журам, гэрээний дагуу хэрэглэх, үйл ажиллагаагаа уялдуулах
Дэмжлэг үзүүлж буй субъект, хамтрагчид (Жишээ нь: Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжиж буй, хөтөлбөрт оролцож буй бизнесийн болон санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөрүүд нь идэвхжүүлэлт, сурталчилгааны зорилгоор гэрээний үндсэн дээр хэрэглэнэ)		❖ Тэмдгийг заагдсан дүрэм, журам, гэрээний дагуу маркетинг, сурталчилгааны зориулалтаар хэрэглэх ❖ Тэмдэг хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэх	

Дэмжлэг үзүүлэх	Дэмжих үйл ажиллагаа	Төсөл хөтөлбөрүүд <i>(Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах, дэмжих, эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажилладаг олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүд тохирлын тэмдэг хэрэглэгч байгууллагад бизнесийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэх мэт)</i>	<ul style="list-style-type: none"> <li>❖ Тэмдгийг заагдсан дүрэм, журам, гэрээний дагуу маркетинг, сурталчилгааны зориулалтаар хэрэглэх</li> <li>❖ Тэмдэг хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэх</li> </ul>
		Банк, санхүүгийн байгууллагууд <i>(Жишээ нь Голомт банкны эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан зээл, санхүүгийн бүтээгдэхүүнтэй уялдуулах)</i>	<ul style="list-style-type: none"> <li>❖ Санхүүжилтийн оновчтой загвар санал болгох</li> <li>❖ Тэмдгийг заагдсан дүрэм, журам, гэрээний дагуу маркетинг, сурталчилгааны зориулалтаар хэрэглэх</li> <li>❖ Тэмдэг хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэх</li> </ul>
		Бусад <i>(Дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах сонирхолтой оролцогч тал)</i>	<ul style="list-style-type: none"> <li>❖ Тэмдгийг заагдсан дүрэм, журам, гэрээний дагуу маркетинг, сурталчилгааны зориулалтаар хэрэглэх</li> <li>❖ Тэмдэг хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэх</li> </ul>

Эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан тохирлын тэмдгийг олгох үйл явцын оновчтой хувилбарыг дор үзүүлэв.

**Зураглал 5. Тохирлын тэмдэг олгох үйл явц**



## Хэрэглэгч:

Тохирлын тэмдгийн хамрах хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг хуулийн этгээд, хувь хүн нь тэмдгийн хамрах хүрээ, стандартад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээндээ тэмдэг хэрэглэх хүсэлтийг тэмдэг эзэмшигч байгууллагад гаргах бөгөөд тэмдгийг бүтээгдэхүүн, үйлчилгээндээ хэрэглэхдээ брэндийн удирдамжийг мөрдөх үүрэг хүлээнэ.

## Тохирлын тэмдэг эзэмшигч/Тохирлын үнэлгээний байгууллага:

Тохирлын тэмдэг эзэмшигч эсвэл тохирлын үнэлгээний хөндлөнгийн байгууллага нь эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан тэмдгийн хамрах хүрээ, тэмдэг олгох үйл явцыг тодорхойлох, тэмдгийг олгох, хянах үйл ажиллагааг хариуцан ажиллана. “Эмэгтэй бизнес эрхлэгч” гэдгийг хэрхэн, яаж тодорхойлох, ямар бизнест тэмдэг олгох зэргийг нарийвчлан тодорхойлохоос гадна брэндингийн бодлого, стратегийг тодорхойлж, мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах нь чухал.

### Хүснэгт 4. Тохирлын тэмдгийн оролцоогчдын эрх, үүрэг

	Гүйцэтгэх үндсэн үүрэг
Гүйцэтгэх захирал	<ul style="list-style-type: none"><li>• Тохирлын тэмдгийг хөгжүүлэх, баталгаажуулах үйл явцыг бий болгох, батлах</li><li>• Тохирлын тэмдэг олгох үйл явцыг зохион байгуулах</li><li>• Тохирлын тэмдэг олгох, цуцлах шийдвэр гаргах</li><li>• Тохирлын тэмдгийн олгох бүтэц зохион байгуулалтыг бий болгох, батлах</li><li>• Тохирлын тэмдгийн зорилго, стратегийг батлах</li></ul>
Баталгаажуулалтын алба	<ul style="list-style-type: none"><li>• Тохирлын тэмдгийн шалгуур, шаардлагад нийцэж байгаа эсэхийг тогтоох</li><li>• Баталгаажуулалтын дүрэм журмыг бий болгох, үйл ажиллагаандаа мөрдөх</li><li>• Сургалт зохион байгуулах</li><li>• Тохирлын тэмдгийн зохистой хэрэглээнд хяналт тавих</li></ul>
Баталгаажуулалтын менежер	<ul style="list-style-type: none"><li>• Тохирлын тэмдгийн баталгаажуулалт, магадлах хяналтын хугацааг тогтоох</li><li>• Тохирлын үнэлгээ хийх</li></ul>
Орон тооны бус хороод (Заавал бус)	<ul style="list-style-type: none"><li>• Баталгаажуулалтын тохирлын үнэлгээтэй холбоотой санал, гомдол хүлээн авах, шийдвэрлэх</li><li>• Байгууллагын ажилтны ёс зүйтэй холбоотой санал гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх</li></ul>
Хэрэглэгч	<ul style="list-style-type: none"><li>• Тохирлын тэмдэг хэрэглэх дүрэм, журмыг дагаж мөрдөх</li><li>• Үйл ажиллагаандаа болон бүтээгдэхүүний чанар стандартыг мөрдөх, хангах</li><li>• Тохирлын тэмдгийн нэр хүндийг унагахгүй байх</li></ul>



## Хамтын тэмдгийн брэндинг: газарзүйн байршил, онцлог болон нийлүүлэлтийн сүлжээний өртөг зэргийг харгалзан үзэх нь

Олон жилийн туршид хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг газарзүйн онцлогт тулгуурлан брэндинг хийсээр ирсэн ба энэ нь тухайн бүтээгдэхүүний чанар нь бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн буюу боловсруулсан газар нутгийн онцлогоос шууд хамааралтай байдагтай холбоотой. Ийм төрлийн бүтээгдэхүүний сонгодог жишээ бол бяслаг юм. Бяслагны чанар нь боловсруулалт хийсэн нутаг орноос ихээхэн шалтгаалдаг бөгөөд Английн Lancashire cheese, Италийн Parmigiano-Reggiano cheese зэргийг жишээ болгон дурьдаж болно.

Монголын нөхцөлд газарзүйн онцлогт тулгуурласан брэндинг хийхдээ Монголын сарлагийн бяслаг гэх мэт тухайн бүтээгдэхүүний болон тухайн бүс нутгийн онцлогийг тусган харуулж болох юм. Хамтын болон тохирлын тэмдэгийг нэвтрүүлснээр Монгол үйлдвэрлэгчид бүс нутагтаа онцлог байж чадах бүтээгдэхүүний нэр хүндийг хамгаалах тогтолцоог бий болгож чадахаас гадна чанарын өндөр стандартыг нэвтрүүлж, мөрдүүлэхэд дотоодын оролцогч талууд хоорондын хамтын ажиллагааг сайжруулах боломжтой юм.

### Жишээ:

Тухайн орон нутгийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон хэрэглэгчдийг хамгаалах зорилгоор Европын холбоо бүтээгдэхүүнийг газарзүйн онцлог, байршилаар бүртгэж, тэмдэг олгох доорх 3 төрлийн аргыг бий болгожээ. Үүнд:



#### 1. Protected designation of origin (PDO):<sup>7</sup>

Гарал үүслийг тодорхойлсон хамгаалалт. Зөвхөн тухайн газар нутагт орон нутгийн үе дамжин уламжлагдан ирсэн нууц арга, технологиор боловсруулан, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнүүдийг энэ аргаар бүртгэнэ.

Жишээ: Шампан дарс (Champagne) нь зөвхөн Францын Шампан мужийн бүс нутагт тусгай журмын дагуу үйлдвэрлэсэн оргилуун дарс бөгөөд усан үзмийн тариалангийн тусгай арга барилыг шаарддаг, усан үзмийг зөвхөн тухайн тогтоосон бүс нутгаас хурааж аван тусгай үйлдвэрлэлийн арга технологиор үйлдвэрлэдэг.

Монголын нөхцөлд газар зүйн онцлогийг харгалзан Увс аймагт ургуулсан чацарганыг ийм төрлийн аргаар бүртгэх боломжтой.

<sup>7</sup> Geographical indications and quality schemes explained (europa.eu)



## 2. Protected geographical indication

**(PGI):<sup>8</sup>** Газарзүйн байршлыг тодорхойлсон хамгаалалт. Түүхий эдийн бэлтгэл, боловсруулалт, үйлдвэрлэлийн дор хаяж нэг нь тухайн заагдсан газар нутагт зохион байгуулагдсан байхыг шаарддаг.

Жишээ нь, Эстони улсад 2008 онд архи үйлдвэрлэл дээр газар зүйн байршлыг тодорхойлсон хамгаалалт (PGI) бий болгосон ба үүний дагуу архи үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа бүх түүхий эд, тэр дундаа ус, спирт зэрэг нь Эстонид үйлдвэрлэгдсэн, энэ улсаас гаралтай байхыг шаарддаг. Үүний дагуу архийг үйлдвэрлэхэд хэрэглэж буй ус нь тодорхой шаардлага хангасан ундны ус байх ёстой ба бүтээгдэхүүнд ашиглаж болох нэмэлт нь орон нутгийн үр тариа эсвэл төмс ашиглан хийсэн органик амтлагч нэгдлүүд байдаг байна. Монголын нөхцөлд ийм төрлийн аргаар Булган аймгийн айргийг брэнджүүлж бүртгүүлэх боломжтой бөгөөд ингэхдээ үйлдвэрлэлийн технологийн стандарт, шаардлагыг нарийвчлан зааж өгч болох юм.



## 3. Traditional specialty guaranteed-TSG:<sup>9</sup>

Уламжлалт аргын баталгаа, хамгаалалт. Энэ ойлголт нь бүтээгдэхүүний гарал үүсэл, газарзүйн байрлалтай хамааралгүй ба орц найрлага болон үйлдвэрлэх арга нь уламжлалт аргаар хийгдсэн гэдгийг баталгаажуулна. Жишээ нь, кабаносси гэгддэг Польшоос гаралтай гахайн махаар хийсэн урт, нимгэн, утсан хиам юм. Тус хиамыг утаж амтлах уламжлалт аргыг TSG-ээр баталгаажуулсан.

Монголын нөхцөлд айраг, хорхог зэрэг бүтээгдэхүүнийг брэнджүүлж, үйлдвэрлэлийн уламжлалт технологийг хадгалан үлдэх боломжтой.

Зах зээлд нийлүүлж буй хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний төрөл зүйлийг олшруулах, тэдгээрийн онцлог шинж, чанарын талаар үнэн, зөв мэдээлэл хүргэх, улмаар бүтээгдэхүүний нэршлийг хууль бусаар болон хуурамч бүтээгдэхүүнд ашиглахаас хамгаалах зорилгоор эдгээр бүртгэлийн аргачлалуудыг бий болгосон байна. Бүтээгдэхүүний бүртгэлд газарзүйн нэршлийг оруулах нь хэд хэдэн давуу талтай. Тухайлбал, Европын холбооны (ЕХ) газар нутагт бараа бүтээгдэхүүнийг хуулбарлан хуурамчаар нэр зүүхээс хамгаална, орон нутгийн болон ЕХ-ны хэмжээнд бараа

<sup>8</sup> Geographical indications and quality schemes explained (europa.eu)

<sup>9</sup> Geographical indications and quality schemes explained (europa.eu)

бүтээгдэхүүний таниулна, сурталчилна, тухайн газар орны бүтээгдэхүүний эрэлтийг зах зээлд бий болгоно, мөн бараа бүтээгдэхүүний үнийг өндөр тогтоох боломжийг бүрдүүлнэ.

Европын холбоонд хийсэн судалгаагаар хэрэглэгчид нь газарзүйн онцлог байршилаар бүртгэлтэй бараа бүтээгдэхүүнд дунджаар 18% илүү үнэ төлөхөд бэлэн байдаг хэмээн тогтоогдсон байна. PDO болон PGI аргачлалаар бүртгэгдсэн бол тухайн бараа бүтээгдэхүүнд хамаарах нэр томъёо, бараа, бүтээгдэхүүний онцлог, шинж чанар, бүс нутгийн талаарх мэдээлэл, гарал үүслийг баталгаажуулах мэдээлэл мөн үйлдвэрлэлийн онцлог арга, аргачлалын талаар гэх мэт нарийвчилсан мэдээ, мэдээллийг бүрдүүлж өгөх шаардлагатай байдаг.

Бүртгэл хийлгэх хүсэлтийг зөвхөн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид гаргах эрхтэй байдаг. Хэд хэдэн газарзүйн байршлаас хүсэлт гаргах бол тус бүс нутгуудын төлөөлөгчдийн нэгдэл, холбоо хүсэлтийг гаргана. Хамтын тэмдэг нь бараа, бүтээгдэхүүний маркетингд томоохон нөлөөг үзүүлдэг ба судалгаанаас харахад PGI тэмдэг нь чанар гэдэгтэй хоршин ойлгогддог бөгөөд борлуулалтын процесст оролцогчдын хоорондын итгэлцлийг нэмэгдүүлдэг гэжээ.

Үе дамжин уламжлагдан ирсэн уламжлалт аргаар үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүнийг TSG тэмдгээр хамгаалах ба энэхүү тэмдгийн онцлог нь газарзүйн байршлаас үл хамаарсан, уламжлалт ахуйг дэмжихэд чиглэсэн ба хэрэглэгчдэд тухайн бүтээгдэхүүний онцгой шинж чанарын талаар нэмэлт мэдээлэл өгдөг юм.

TSG-д бүртгүүлэх хүсэлтэд нэг болон түүнээс олон хэл дээр бүтээгдэхүүний нэршил, нэршлийг хадгалах эрх хүсэж буй эсэх, бараа бүтээгдэхүүний үндсэн шинж чанар, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн процесс, арга технологи, тухайн бүтээгдэхүүний уламжлалт үйлдвэрлэлийн гол элементүүдийн тухай мэдээлэл зэргийг оруулах шаардлагатай байдаг.

TSG нь тухайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн уламжлалт арга, технологийг баталгаажуулах боловч бүтээгдэхүүний оюуны өмчийн найдвартай хамгаалалт болж чаддаггүй. TSG-ийн нэг жишээ нь уламжлалт аргаар хийсэн Mozzarella бяслаг болон Нидерландын Voegenkaas бяслаг юм. Эдгээрийн оюуны өмчийн эрхийн хамгаалалт зөвхөн Нидерландад хүчин төгөлдөр байна.

**1.9.1 Дүгнэлт**

Өнөө үеийн бизнесийн орчинд эмэгтэй бизнес эрхлэгчид, ялангуяа бичил болон жижиг бизнес эрхлэгчид санхүүжилт татах хүндрэлтэй, борлуулалтын сувгууд хязгаарлагдмал, маркетингийн мэдлэг, туршлага хомс зэрэг маш олон хүндрэл, бэрхшээлтэй тулгардаг. Эдгээр бэрхшээлийг хамтын хүчээр даван туулж, тогтвортой байдал, хөгжилд хүргэх шийдлүүд шаардлагатай байна. Хамтын болон тохирлын тэмдэг нь бизнесийн нэр хүндийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, үйл ажиллагааг нэгтгэх, үр ашигтай байдлаар зохион байгуулах боломжийг олгосноор бизнес эрхлэгчдийг дараагийн шатанд хүргэх чухал арга хэрэгслүүд байж чадах юм.

Хамтын тэмдгийг бизнес эрхлэгчдийн нэгдэл, холбоод, кластерууд хамтран эзэмшиж, ашигласнаар хамтын брэнд бүтээгдэхүүнийг зах зээл дээр таниулж, тухайн бүлэг, нэгдлийн хүрээн дэхь хамтын ажиллагааг бэхжүүлнэ. Харин тохирлын тэмдэг нь тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын баталгаа болж өгдөг ба холбогдох стандарт, шаардлагыг хангаж байгаа гэдгийг баталгаажуулах юм. Хамтын болон тохирлын тэмдгүүд хоорондын ялгааг сайтар ойлгож, мэдэх нь тэдгээрийг үр дүнтэй нэвтрүүлж, хэрэгжүүлэхтэй шууд холбоотой.

Монголын нөхцөлд эмэгтэй бизнес эрхлэгчдийн онцлог шинж чанарт тохирсон хамтын болон тохирлын тэмдгийг нэвтрүүлснээр компаниудын өрсөлдөх чадварыг сайжруулж, улмаар Монгол улсын эдийн засгийг солонгоруулахад хувь нэмэр оруулах юм. Эдгээр тэмдгийн хүрээнд хамтарсан брэндиг хийснээр үйл ажиллагааны зардлыг бууруулж, борлуулалтын ашиг, орлогыг нэмэгдүүлэхээс гадна кластеруудын инновацийг дэмжинэ.

Олон улсад бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжихийн ач холбогдлыг аль хэдийнэ хүлээн зөвшөөрч, энэ чиглэлд олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа ба International Workshop Agreement ISO IWA 34:2021-г боловсруулан баталж, эмэгтэй эзэмшилтэй бизнес болон эмэгтэй удирдлагатай бизнес зэргийг нарийвчлан тодорхойлж өгсөн нь чухал ач холбогдолтой болсон юм. Энэхүү гэрээ батлагдсантай холбоотой эмэгтэй бизнес эрхлэгчид тодорхой шалгуурт нийцэх дундын тохирлын тэмдгийг бий болгон хөгжүүлж, улмаар эмэгтэй бизнес эрхлэгчдийн чадавхийг бэхжүүлэх, урамшууллын хөтөлбөрүүдэд хамрагдах боломжтой юм.

Гэсэн хэдий ч хамтын болон тохирлын тэмдэг нэвтрүүлэхэд хууль, эрхзүйн орчин, санхүүжилтийн тогтолцоо, оюуны өмчийн хамгаалалт зэрэгтэй холбоотой тодорхой хүндрэл, бэрхшээл, эрсдэлүүд үүсэх магадлалтай гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй юм. Эрсдэлийг даван туулахын тулд гишүүн байгууллагууд сайтар төлөвлөж, уялдаа холбоотой ажиллах нь чухал билээ.

Хамтын болон тохирлын тэмдгийг нэвтрүүлэн, хэрэгжүүлж чадвал бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хувьд өөрсдийн өрсөлдөх чадварыг сайжруулж, шинэ зах зээлд нэвтрэх боломжтой болохоос гадна Монгол улсын цаашдын тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах юм. Эдгээр тэмдэг нь дан ганц брэндинг хийх арга биш юм. Эдгээр нь тулгарч буй саад, бэрхшээлийг хамтдаа даван туулж, бизнесийн кластер зарчмаар хөгжих боломжийг олгох арга хэрэгсэл юм.

### 1.9.2 Зөвлөмжүүд

1. **Засгийн газрын дэмжлэг:** Монгол улсын Засгийн газрын зүгээс татварын хөнгөлөлт, урамшуулал, санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх замаар жижиг, дунд бизнес эрхлэгчдийг бодлогоор дэмжих, тэдгээрийг томоохон аж ахуйн нэгж байгууллагуудтай холбон хамтын ажиллагааг өргөжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай. Эдгээр арга хэмжээгээр дамжуулан бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн үйл ажиллагааг цаашид өргөжүүлэн, хөгжүүлж, эрсдэлд тэсвэртэй болоход нь дэмжлэг үзүүлэх юм.
2. **Хууль, эрхзүйн орчин:** Кластерийг бий болгож, хөгжүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг тодорхой, тогтвортой болгоход дэмжлэг үзүүлэх хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай. Хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээнд кластерийн санхүүжилтийн механизм, оюуны өмчийн бүртгэл, хамгаалалт, бүтээгдэхүүний чанар, стандарт зэрэгтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан боловсруулах шаардлагатай.
3. **Санхүүжилтийн механизм:** Кластерийн хөгжлийг дэмжих, бизнесийн байгууллагууд хамтын төсөл, хөтөлбөрт санхүүжилт авах боломжийг нээх үүднээс урт хугацаандаа тогтвортой ажиллах санхүүжилтийн механизмыг бий болгож, хөгжүүлэх шаардлагатай. Энэхүү санхүүжилтийн бүтэц нь кластер сүлжээний тогтвортой байдлыг хангахад чиглэсэн байх нь зүйтэй.
4. **Оюуны өмчийн хамгаалалт:** Хамтын болон тохирлын тэмдэгтэй холбоотой оюуны өмчийн хамгаалалтыг бий болгож, сайжруулах шаардлагатай. Холбогдох дүрэм, журамд оюуны өмчийн хамгаалалтын цар хүрээг тодорхой зааж өгөхөөс гадна зөрчил гарсан тохиолдолд ямар арга хэмжээ авах мөн зохицуулалтын биелэлтийг хэрхэн хангуулах талаар тусгасан байх хэрэгтэй.
5. **Стандартчилал, нэгдсэн тодорхойлолт:** Эмэгтэй эзэмшилтэй болон эмэгтэй удирдлагатай бизнесүүдийн тодорхойлолт, тэдгээрт тавигдах шаардлага зэргийг International Workshop Agreement ISO IWA 34:2021-ийн дагуу нарийвчлан тодорхойлох, стандартчилах шаардлагатай. Энэ нь бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн тохирлын тэмдгийг бий болгох үндэс, суурь нь болох юм.

6. **Кластер байгуулах, хөгжүүлэх:** Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд нэгдэн нийлж, газарзүйн эсвэл салбарын онцлог дээрээ үндэслэн кластер байгуулан ажиллахыг дэмжих шаардлагатай. Кластерийн зохион байгуулалтанд орсон бизнесүүд хамтын тэмдэгтэй болох чиглэлд хамтран ажиллах бөгөөд үүгээрээ дамжуулан зах зээл дээрх өөрсдийн нэр хүндийг өсгөж, хамтын ажиллагааг сайжруулах боломжтой.
7. **Чанарын стандарт:** Хамтын болон тохирлын тэмдэг нэвтрүүлэхтэй холбоотойгоор бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт тавих стандарт, шаардлагыг сайжруулах хэрэгтэй. Стандарт, шаардлагад нийцсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгосноор тухайн тэмдгийн нэр хүнд, үр ашгийг нэмэгдүүлж чадна.
8. **Боловсролын хөтөлбөр:** Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд хамтын болон тохирлын тэмдэгтэй болохын ач холбогдол, үр нөлөө, тэдгээрийг хэрхэн, яаж бий болгож, нэвтрүүлэх талаар чадавх бэхжүүлэх, боловсрол олгох хөтөлбөр, сургалтыг зохион байгуулах шаардлагатай. Тэмдгийг амжилттай нэвтрүүлж, хэрэгжүүлэхэд мэдлэг, ойлголт, боловсрол маш чухал.

Дээрх санал, зөвлөмжүүдийн дагуу бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг дэмжиж, хөгжүүлснээр Монгол улс эмэгтэй бизнес эрхлэгчдийг чадавхжуулахаас гадна тэдгээрийн зах зээл дээрх өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, улмаар улс орны эдийн засгийг солонгоруулах, хөгжүүлэх чиглэлд ахиц дэвшил гаргаж чадна. Эдгээр зорилтуудад хүрэхэд хамтын тэмдэг болон тохирлын тэмдэг нь чухал ач холбогдол, үүрэгтэй юм.